# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2022 ОН)

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| НЭГ: ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ | | | | | | |
| Стратегийн зорилго 1: Монгол Улсын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэхэд хувь нэмрээ оруулах | | | | | | |
| Зорилт 1.1 | | Монгол Улсын хүний эрх эрх чөлөөний үндэсний индексийг тодорхойлох, хууль тогтоомж, бодлого шийдвэрийн Төслийн зардлаар боловсруулахад хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индексийг боловсруулах | | | | |
| 1.1.1 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг боловсруулах, өргөн барих, англи хэл рүү орчуулах, илтгэлийг хэвлүүлэх, сурталчлах, түгээх. | Боловсруулж, сурталчилсан илтгэлийн тоо<br><br>Тамгын газар | 20 | 21 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг "Ковид-19 цар тахлын хүний эрх, эрх чөлөөний сургамж", "Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх", “Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал”, “Гэр бүлийн хүчирхийллээс ангид байх эрх”, "Цэргийн алба хаагч хоорондын дүрмийн бус харьцааны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ", "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ" гэсэн 6 багц сэдвээр боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар 4 дүгээр сард хүргүүлсэн. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан “Авах зарим арга хэмжээний тухай" 49 дүгээр тогтоол батлагдсан.<br>Монгол хэл дээр 1000 хувь хэвлүүлснийг байгууллага, албан тушаалтан зочид төлөөлөгчдөд тараан өгч сурталчилан таниулаад байна.<br>Илтгэлийг сурталчилах, олон нийтэд түгээх ажлын хүрээнд МҮОНРТВ болон арилжааны телевизүүдийн “Мэдээллийн хөтөлбөр”, “Зочны цаг”, “Ярилцлагын нэвтрүүлэг”-т 30 гаруй мэдээ, мэдээлэл, Зууны мэдээ, Өдрийн сонин, Өнөөдөр, Өглөөний сонинуудад хүний эрхийн тодорхой асуудлыг хөндсөн нийтлэл, сурвалжлага, мэдээ мэдээлэл 28 удаа нийтэлж сэдэв тус бүрээр 25 постер, УИХ-ын 49 дүгээр тогтоолын агуулгаар 6 постер бэлтгэж цахим орчинд түгээсэн. Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилсан. | Үнэлгээ-90% |
| 1.1.2 | Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индексийг боловсруулах ажлыг эхлүүлэх. | Боловсруулж эхэлсэн индексийн тоо<br><br>СДШХШХ | 0 | 1 | Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх тус бүрийн шалгуур үзүүлэлт, индекс боловсруулах арга, аргачлал ажлын үр дүнг Комиссын 10 дугаар сарын хуралдаанаар, 12 дугаар сард Иргэний нийгмийн зөвлөлийн хуралд, эрдэмтэн, судлаачид, төрийн байгууллагын албан тушаалтан, НҮБ-ын Хүн амын сан, бусад байгууллагын төлөөлөлд тус тус танилцуулж Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индексийг боловсруулах ажлыг эхлүүлсэн. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| 1.1.3 | УИХ-д өргөн барьсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалуудад хүний эрхийн үүднээс саналаа боловсруулахад оролцох. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь<br><br>СДШХШХ | 0 | 100% | Монгол Улсын Их хурлын Тамгын газраас Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалуудыг шинэчилж, санал авахаар хандаагүй. | Үнэлгээ-0% |
| 1.1.4 | "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ыг хүний эрхийн үүднээс боловсронгуй болгох санал боловсруулж, ХЗДХЯ-д хүргүүлэх. | ХЗДХЯ-д хүргүүлсэн саналын тоо<br><br>СДШХШХ | 0 | 1 | "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ыг шинэчлэх эсэх асуудлаар ХЗДХЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж 2023 онд аргачлалын хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар дүн шинжилгээ хийлгэсний үндсэн дээр шийдвэрлэхээр тохиролцов. | Үнэлгээ-70% |
| Зорилт 1.2 | | Хүний эрхийг хангах, хамгаалах төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах | | | | |
| 1.2.1 | Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлсон болон хүний эрхийг хангах, хамгаалахад ач холбогдолтой дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад санал өгөх.<br>- Тайван жагсаал цуглаан хийх эвлэлдэн нэгдэх;<br>- Боловсролын багц хууль<br>- Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай;<br>- Эрүүгийн багц хууль тогтоомжийн холбогдох хэсэгт. | Санал өгсөн хуулийн төслийн тоо<br><br>СДШХШХ | 27 | 31 | Тайлант хугацаанд 11 хууль тогтоомжийн төсөлд санал боловсруулж хүргүүлж ажилласан. Үүнд:<br>1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>2. Эрүүгийн хууль;<br>3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;<br>4. Боловсролын багц хуулийн төсөл;<br>5. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл;<br>6. Байгальд зорчих, аялах эрхийн тухай хуулийн төсөл;<br>7. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл;<br>8. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль;<br>9. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл;<br>10. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон дагалдах хуулийн төсөл.<br>11. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, түүнийг дагалдах хуулийн төсөл. | Үнэлгээ 70% |
| 1.2.2 | Хүний эрх, эрх чөлөөний асуудлаар дүн, шинжилгээ хийж | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс | 24 | 30 | Тайлант хугацаанд ХЭҮК-оос санал хүргүүлээгүй.<br>Комиссоос 4 зөвлөмжийг боловсруулж, хүргүүлсэн. Үүнд: | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Комиссын санал, зөвлөмж хүргүүлэх. | урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан санал, зөвлөмжийн тоо<br><br>СДШХШХ | | | 1. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоод цэргийн командлагч, хошууч генерал Ж.Болдод “"Монголдоо тайван сайхан амьдаръя" жагсаал цуглааны үеэр иргэдэд хүч хэрэглэсэн асуудлаар”<br>2. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд “Боловсролын салбарын хэмжээнд суралцагчдын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхийг хангах, тэдний амь нас, эрүүл мэндийг аливаа эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалах асуудлаар”<br>3. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоод цэргийн командлагч, хошууч генерал Ж.Болдод “Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон бусад эрхийг баталгаатай эдлүүлэх талаар”<br>4. 4.Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт “Жагсаал цуглаанд 20 гаруй иргэд шөнөдөө хононо суулт хийж тэдний аюулгүй байдлыг цагдаа, төрийн тусгай алба хаагчид 24 цагаар хангаж ажиллаж байгаа талаар зөвлөмжийг тус тус хүргүүлсэн. | Үнэлгээ-100% |
| 1.2.3 | Хүүхэд хамгааллын тогтолцооны үр нөлөө, мэргэжлийн байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэх. | Холбогдох газарт хүргүүлсэн санал зөвлөмжийн тоо<br><br>ХЭССХ | 0 | 1 | "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхдийн эрх" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, танхимаар 93, zoom 100+ оролцогчийг хамруулсан. Хэлэлцүүлгийн үеэр илтгэгч, панелист, оролцогчдоос гаргасан саналыг нэгтгэн зөвлөмжийн төсөл боловсруулж ЦЕГ, ШШГЕГ, ХЗДХЯ, УЕП, ХНХЯ, ШЕЗ-д хүргүүлэхээр бэлтгэсэн. | Үнэлгээ-70% |
| Зорилт 1.3 | | Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх | | | | |
| 1.3.1 | Хүний эрхийг хангах 2003 оны үндэсний хөтөлбөрийг үнэлүүлэх, шинэчлэн боловсруулах санал боловсруулах. | Боловсруулсан саналын тоо<br><br>СДШХШХ | 0 | 1 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 44 дүгээр тушаалаар байгуулагдсан "Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсэгт Комиссын гишүүд, нэгжийн удирдлагууд орж 30 гаруй санал өгч ажилласан бөгөөд "Хүний эрхийг хангах 2003 оны үндэсний хөтөлбөр"-ийн биелэлтийг нэгтэн МУ-ын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд өнгөрөгч 9 дүгээр сард хүргүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 11 дүгээр сард зохион байгуулагдсан “Бизнес ба Хүний эрх” форумд ажлын хэсгийн ахлагч танилцуулсан. | Үнэлгээ-100% |
| Зорилт 1.4 | | Гамшгийн онцгой нөхцөл байдал, онц байдлын үед хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | | | | |
| 1.4.1 | Онц байдал, гамшгийн үед хүний эрхийг хангаж хамгаалах | Зохион байгуулсан нөлөөллийн | 0 | 100% | КОВИД-19 цар тахлын хүний эрхийн сургамжид үндэслэн нийгмийн гоц халдварт өвчнийг тандан судлах, урьдчилан сэргийлэх, хариу | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | үндэсний бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах. | ажиллагааны хэрэгжилтийн хувь<br><br>ГХАТ<br>СДШХШХ<br>ХЭССХ | | | арга хэмжээг тодорхойлох байгууллагын тогтолцоог үнэлж, халдварт өвчний үед нийгмийн амьдрал, хүмүүсийн олон янзын хэв байдалд нийцтэй хариу арга хэмжээг төлөвлөх бодлогын шинэ чиглэл бий болгох, мөн олон улсын байгууллагуудтай Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоог боловсронгуй болгоход хамтран ажиллах зорилгоор 2022.05.24-ны өдөр “КОВИД-19 цар тахлын хүний эрх, эрх чөлөөний сургамж” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг төрийн удирдах албан тушаалтан, ОУБ-ын суурин төлөөлөгчийн газруудын тэргүүн нарыг оролцуулан зохион байгуулах зэргээр нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. | |
| Стратегийн зорилго 2: Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих, бодитой, эерэг өөрчлөлт гаргах | | | | | | |
| Зорилт 2.1 | | Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналт тавих, энэ чиг үүргийг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгох | | | | |
| 2.1.2 | Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br><br>СДШХШХ | 20% | 100% | Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сум, Төв аймгийн Баянжаргалан сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд ХЭНБҮ хийсэн судлаачийн тайлантай танилцаж, судалгааны тайланг дахин сайжруулж НҮБ-ын Байгаль орчны мониторингийн төслийн нэгжид хүргүүлсэн. | Үнэлгээ-50% |
| 2.1.3 | Олон улсын шинжээчдийн оролцоотойгоор Монгол Улсын төсөвт Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх бэлтгэл ажлыг хангах. | Дүн шинжилгээний ажлыг эхлүүлсэн байна.<br><br>СДШХШХ | 0 | 100% | Эмнэсти Интернэшнл Монголиа ТББ-аас зохион байгуулсан "Эрүүл мэндийн салбарын төсвийн мониторинг"-ийн хэлэлцүүлэгт оролцсон. Комиссын зүгээс төсвийн мониторинг хийхэд зөвлөх боломжтой экспертүүдтэй уулзах хүсэлтийг хүргүүлсэн.<br>УИХ-ын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Төсвийн хяналт шинжилгээний хэлтэс, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай Монгол Улсын төсөвт Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх бэлтгэл ажлыг хангах төсөвт дүн шинжилгээ хийх арга, аргачлал, анхаарах асуудлын талаар мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулж, Засгийн газрын 2021 оны 160 тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналтыг бүртгэх журам”-д хүний эрхийн асуудлыг нэг шалгуур үзүүлэлт болгон оруулахаар шийдвэрлэсэн. | Үнэлгээ-90% |
| 2.1.4 | Боловсролын салбар дахь хүний эрхийн зарим асуудлаар мониторинг хийх. | Мониторинг хийсэн байна.<br><br>ХЭССХ | 0 | 100% | БСШУ-ны сайдын 2022 оны А/86 дугаар тушаалаар байгуулагдсан "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ажлын даалгавар боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллав. | Үнэлгээ-70% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж холбогдох хууль журмын дагуу шалгаруулалт явуулсны үндсэн дээр хамгийн сайн үнэлэгдсэн "Эс Ай Си Эй" ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмжийг БШУЯ-нд хүргүүлсэн. Улмаар БШУЯ "Эс Ай Си Эй" ХХК-тай гэрээ байгуулж судалгааны ажлыг эхлүүлсэн. | |
| 2.1.5 | Их, дээд сургуулийн орчин дахь багш, оюутнуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн хэрэгжилт, өнөөгийн байдалд хяналт, үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах. | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br><br>СДШХШХ | 20% | 100% | “Их дээд сургуулийн оюутан залуусын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилт” судалгааны удирдамжийг баталж, судалгааны ажлын гүйцэтгэгчээр “Цаглашгүй мэдлэг” НҮТББ-ыг шалгарсан. Судалгааны баг Дархан, Орхон-Уул аймаг дахь их, дээд сургуулийн дотуур байрны нөхцөл байдал, орчин нөхцөлтэй танилцаж, багш оюутнуудтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, судалгаа хийж гүйцэтгэсэн. | Үнэлгээ-100% |
| 2.1.6 | Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.<br><br>ХЭССХ | 0 | 100% | Монголын эмэгтэйчүүдийн холбоогоор Жендэрийн чанарын түвшинг тодорхойлох судалгааг гүйцэтгүүлэхээр ажлын даалгавар боловсруулан ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан. Жендэрийн чанарын түвшинг тодорхойлох судалгааг гэрээнд заасан хугацаанд МЭХ-ноос хүлээн авч Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийн “Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх” бүлэгт тусган боловсруулан УИХ-д өргөн барьсан.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа болон Жендэрийн чанарын түвшинг тодорхойлох судалгааны үр дүнг олон нийтэд таниулах, сурталчлах зорилгоор 4 видео контентын төслийг НҮБХХ, Койка ОУБ-д танилцуулав. | Үнэлгээ-100% |
| 2.1.7 | "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийг төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br><br>ХЭССХ | 20% | 100% | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Койка ОУБ-аас хамтран хэрэгжүүлж байгаа "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд ХЭҮК-оос 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.<br>Төслийг төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх зорилгоор Комиссын дарга, Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга нарын хамтарсан тушаалаар "Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтэд үнэлгээ хийх", "Жендэрийн мэдрэмжтэй хүний эрхийн манлайлагч тодруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.<br>“Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтэд үнэлгээ хийх”, “Социологийн боловсрол төв” НҮТББ, “Жендэрийн | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдрэмжтэй манлайлагч тодруулах" ажлыг МУИС-ийн "Социологи, нийгмийн ажлын тэнхим"-ээр гүйцэтгүүлэхээр ажлын даалгавар боловсруулж ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээнд заасан хугацаанд Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтэд үнэлгээ хийх", "Жендэрийн мэдрэмжтэй хүний эрхийн манлайлагч тодруулах" ажлын хүрээнд хийсэн судалгааг хүлээн авсан.<br>"Жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй манлайлагч тодруулах" ажлын урьдчилсан тайланг Койка ОУБ, ЖҮХ, Комиссын дарга, гишүүдэд танилцуулсан.<br>Мөн НҮБХХ-ийн төслийн зөвлөх, төслийн менежерүүд, Койка ОУБ-ын төслийн судлаач, шинжээч, төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж явцын болон дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаж санал дүгнэлт өгч ажиллав.<br>Төслийн хэрэгжилтийн тайланг боловсруулан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Койка ОУБ-д хүлээлгэн өгсөн.<br>Жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй манлайлагч тодруулах" ажлын хүрээнд шалгарсан 33 эрэгтэй жендэрийн мэдрэмжтэй манлайлагч болон 2022 оны 1 дүгээр сард шалгарсан жендэрийн мэдрэмжтэй шилдэг 5 удирдагчийг хамруулсан 1 өдрийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг ЖҮХ, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимтэй хамтран 2023 оны нэгдүгээр сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| 2.1.8 | Ахмад настны эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх | Дүн шинжилгээ хийсэн байна.<br>СДШХШХ | - | 100% | Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй "Ахмад настны эрх, хамгаалал" судалгааны ажлын даалгавар болон удирдамжийг боловсруулж, "Мэргэжлийн Социологичдын Холбоо" ТББ-ыг сонгон шалгаруулсан. Судалгааны хүрээнд 600 ахмад настнаас анкетын судалгаа, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлагыг тус тус хийсэн бөгөөд 7 байгууллагаас ахмад настанд чиглэгдсэн үйл ажиллагааны мэдээлэл, ахмад настны эрх, хамгааллын судалгааны тайланд сайжруулалт хийлгэсэн. | Үнэлгээ-100% |
| 2.1.9 | Хүний эрх ба технологи судалгаа хийх бэлтгэл ажлыг тодорхойлох | Бэлтгэл ажлыг хангасан байна.<br>ХХМХХ | - | 100% | "Шинэ технологийн хүний эрхийн эрсдэл Монгол Улсад: бодлого, эрх зүйн орчин, нөхцөл байдал" тандалтын судалгааг С.Тэнгис судлаачаар гүйцэтгүүлж, эцсийн тайланг хянаж, хүлээн авсан. | Үнэлгээ-100% |
| 2.1.10 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба хүний эрхийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх | Судалгаа, дүн шинжилгээ хийсэн байна. | - | 100% | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх ажлын удирдамжийг боловсруулсан. Үүнд: | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | СДШХШХ | | | 1.Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн ИБУТЭТОУП-ын 9-р зүйлийн 35-ыг орчуулж, Монгол Улс дахь нөхцөл байдалд харьцуулан дүгнэлт хийсэн.<br>2.Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн.<br>3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгдөх дүрэм журмын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн.<br>4.Сэжигтнийг баривчлах ажиллагааны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.<br>5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн.<br>6.Эрүүгийн хуульд заасан ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх. Мөн ДХИС-тай хамтарсан олон улсын хурлын үр дүн, илтгэх хуудас, мэдээлэл, зөвлөмжийг авч Комиссын гишүүдэд танилцуулсан. | Үнэлгээ-90% |
| 2.1.11 | “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх” судалгаа, сургалт | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br>СДШХШХ | 20% | 100% | Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд НҮБ-ын Хүн амын сангийн ажилтнуудтай төсвийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, улирал тутмын уулзалтыг цахимаар зохион байгуулах, хагас жил тутам үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг боловсруулж, “Атлас” тусгай системд оруулах ажлыг гүйцэтгэсэн. НҮБХАС-гийн жилийн тайлангийн уулзалт хэлэлцүүлэгт 11 дүгээр сарын 29-ний өдөр оролцсон. Төслийн санхүүжүүлэгч байгууллага болох НҮБХАС-гийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч талуудад хийгдэх хөндлөнгийн үнэлгээг 12 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулж, үнэлгээний дүнгийн хуралд цахимаар оролцсон. | Үнэлгээ-100% |
| 2.1.12 | Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгаа | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br>Ажлын хэсэг | 20% | 100% | ШШГЕГ-ын харьяа Дархан-Уул аймаг дахь хорих 435, 445, Ховд аймаг дахь хорих 457, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь хорих 423, Улаанбаатар хот дахь хорих 407, 409, 421 дүгээр ангиудад хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын үед авсан санал асуулгын дүнг “Ардчилал судлалын хүрээлэн” ТББ-д хүргүүлсэн. “Хоригдлын ажил, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал” судалгааны ажлыг хийж тайланг хүлээн авсан. | Үнэлгээ-100% |
| 2.1.13 | “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Монгол Улсын төрөөс авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ ба хүний эрхийн | Дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажилласан байна.<br>СДШХШХ<br>ГМШХ | 0 | 100% | “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хуулийн хүрээнд байгууллага, албан тушаалтнаас 2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан болон 2022 оны 1 дүгээр улиралд хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг УИХ-ын түр хороонд тус тус хүргүүлсэн болно. | Үнэлгээ-90% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилт"-д дүн шинжилгээ хийж хяналт тавих | | | | Хуулийн хэрэгжилтийн хүрээнд ХЭҮК-оос 2 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын тайланг жилийн эцсээр нэгтгэж дуусгасан. | |
| 2.1.14 | Монгол Улсын Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийх | Судалгааны ажлыг хийсэн байна.<br>ХЭХХ | 0 | 1 | Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт судалгааг хийлгэхээр "Төв Тусгал" ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. МӨХ, ЦЕГ, МҮЭХ, Хэвлэл мэдээллийн Зөвлөл, Монгол Улсын Дээд шүүхийн тамгын газар зэрэг байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, судалгааны 1900 цахим асуулгыг нэгтгэж, судалгааны агуулгыг тодорхойлж, боловсруулалт хийсэн. | Үнэлгээ-50% |
| Зорилт 2.2 | | ХЭҮК-оос өмнөх жилүүдэд судалж, тодорхойлсон асуудлыг бодитойгоор шийдвэрлүүлэх идэвхтэй үйл ажиллагаа явуулах | | | | |
| 2.2.1 | Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн асрамжийн газар байгуулах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулахад нөлөөлөх | Тогтолцоог сайжруулахад манлайлж ажилласан байна.<br>СДШХШХ | 0 | 100% | Нээлттэй нийгэм форумтай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой нэвтрүүлэг хийлгэхээр шаардлагатай мэдээллийг нэвтрүүлгийн зохиолыг бичиж байгаа сэтгүүлчдэд өгсөн.<br>Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн асрамжийн газар байгуулах асуудлаар ХНХЯ-наас 5 давхар барилгын зураг, төсөв /24 тэрбум төгрөг/-ийг хийлгэсэн боловч УИХ-ын Намрын чуулганаар дэмжигдээгүй хасагдсан. | Үнэлгээ-80% |
| 2.2.2 | Төрийн цэргийн анги байгууллагууд дахь дүрмийн бус харьцаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангуулах | Дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангуулахад манлайлж ажилласан байна.<br>СДШХШХ | 0 | 100% | "Цэргийн алба хаагчдын дүрмийн бус харилцааны нөхцөл байдалд хийсэн үнэлгээ", "Цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд хийсэн дүн шинжилгээ" судалгааны ажлыг хянасан. Энэ ажлын хүрээнд Булган, Хөвсгөл, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ зэрэг аймгууд дахь Хилийн цэргийн анги, байгууллагуудад хяналт шалгалт хийгдэж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажил хийгдсэн.<br>Төрийн цэргийн байгууллагууд дахь дүрмийн бус харьцааны судалгааны хүрээнд ХХЕГ, ЗХЖШ-ын экспертүүдийг оролцуулан 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Төрийн цэргийн байгууллага дахь дүрмийн бус харьцааны судалгааг эмхэтгэх, боловсруулалтыг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. | Үнэлгээ-100% |
| 2.2.3 | ҮАБЗ-д улирал тутам мэдээлэл хүргүүлэх; | Журмын дагуу мэдээлэл хүргүүлсэн байна.<br>ЗУХ, Тамгын газар | 4 | 8 | Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2022 онд зохион байгуулсан, 2023 онд зохион байгуулахаар төлөвлөсөн олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг, зөвлөгөөний талаарх мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хагас бүтэн жилийн байдлаар хүргүүлсэн. | Үнэлгээ-100% |
| 2.2.4 | Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үр нөлөөтэй, хараат бусаар мөрдөн | Хувилбаруудыг тодорхойлсон байна. | 0 | 25% | Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18-р илтгэлийн Дөрөвдүгээр бүлэгт тусгагдсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой илтгэл, зөвлөмжийг судалж | Үнэлгээ-50% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | шалгах нэгж бий болгох талаар өгсөн зөвлөмжүүдийг үнэлэх; | СДШХШХ | | | байна. Оролцогч талуудын түвшний хэлэлцүүлгийг 2023 онд хийхээр төлөвлөсөн.<br>Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын Комисс, БНСУ-ын Цагаатгалын Комисс хамтран 2022 оны 12 дугаар сард зохион байгуулсан хэлэлцүүлэгт “Эрүүгийн хэрэгт хэлсээр шийтгэгдсэн хүмүүсийн эрхийг сэргээх ажиллагаа, эрүүдэн шүүхийн мөрдөн шалгах байгууллагуудын тогтолцоо” сэдвээр илтгэл тавьсан.<br>НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсэг хорих ангиуд, цагдаагийн хэсгүүд, эрүүлжүүлэх байрууд, түр хамгаалах байрууд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх төв, Ахмадын үндэсний төв, Гадаадын иргэдийг саатуулах хэсэг зэрэг 21 газарт ажиллаж, урьдчилсан тайлан, дүгнэлтийг танилцуулсантай холбогдуулж Комиссоос холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулсан. | |
| Стратегийн зорилго 3. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд манлайлах | | | | | | |
| Зорилт 3.1 | | Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн чадавхи бэхжүүлэх болон нөлөөллийн үйл ажиллагаа явуулах | | | | |
| 3.1.1 | Гадаадад оршин сууж, сурч, ажиллаж байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үр дүнтэй, байнгын ажиллагаатай тогтолцоо болгоход Засгийн газар, Гадаад хэргийн яамны санаачлагыг дэмжиж, зөвлөн туслах; | ЗГ, УИХ-д уламжилсан байна.<br>ГХАТ | 0 | 25% | Хилийн чанад дахь Монголчуудын Зөвлөлтэй хамтран цаашид зохион байгуулах үйл ажиллагааны чиглэлийг тогтсон.<br>Бүгд Найрамдах Польш Улсын Варшав хотноо ЕАБХАБ-ын бүс нутаг дахь ХЭҮБ-уудын удирдлагын дээд хэмжээний уулзалтад оролцох үед тус улсад суугаа монгол иргэдтэй, БНСУ-ын Сөүл хотод тус улсын ХЭҮК-оос зохион байгуулсан ХЭҮБ-уудын Түншлэл-2022 арга хэмжээнд оролцох үед БНСУ дахь монгол иргэдтэй хийсэн уулзалтуудыг тус улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамдтай хамтран зохион байгуулсан.<br>Эдгээр уулзалтуудын үр дүнд хилийн чанадад оршин суугаа монгол иргэдийн эрхийн төлөв байдалд Комисс иж бүрэн үнэлгээ хийх талаар тохирсон. Мөн Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын хөтөлбөрийн менежер Даниэл Самтай 10 дугаар сард уулзалт зохион байгуулж хамтын ажиллагааны талаар санал солилцох явцад хилийн чанадад оршин суугаа монгол иргэдийн эрхийн төлөв байдалд үнэлгээ хийх ажлыг хилийн чанад дахь монгол иргэд Монгол Улс дахь гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн урсгалын цогц судалгаа, үнэлгээний хүрээнд хийх боломжийг хамтран судлахаар тогтсон. | Үнэлгээ-70% |
| 3.1.2 | Төрийн албан хаагч хүний эрхийн зөрчил гаргаж байсан эсэх талаар мэдээллийн сан бүрдүүлэх тухай санал хүргүүлэх; | Санал хүргүүлсэн байна. | 0 | 100% | Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланд хүний эрхийн зөрчил гаргасан албан хаагчийн мэдээллийг оруулж байх талаар Төрийн албаны зөвлөлд санал хүргүүлсэн. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | ЗУХ,<br>ГМШХ | | | | |
| 3.1.3 | “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг хэрэгжүүлэхэд оролцох | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br><br>Ажлын хэсэг | 20% | 100% | Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төслийн хүрээнд Дорнод, Ховд, Орхон, Өмнөговь аймагт бүсийн зөвлөлдөх уулзалт, Сэлэнгэ, Говь-Алтай, Баян-Өлгий, Төв, Завхан, Увс, Дорнод аймагт сумдын Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт зориулсан “Хүний эрх ба Жендер” сургалт зохион байгуулж, тус аймгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 2 байгууллагыг сонгон авч тус тус хяналт шалгалт зохион байгуулсан. | Үнэлгээ-100% |
| Гомдол хяналт шалгалтын чиглэлээр | | | | | | |
| 3.1.3 | Хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх; | Хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгсөн тоо<br><br>ГМШХ | 1017 | 1100 | Хүний эрхийн асуудлаар нийт 1127 иргэнд 24604 минутын /утсаар 221, биечлэн 901, цахимаар 5/ зөвлөгөө өгсөн байна. Үүнээс ГМШХ-ийн ажилтнууд 276 иргэнд 3183 минутын, орон нутаг дахь ажилтнууд нийт 851 иргэнд 21421 минутын зөвлөгөө өгсөн байна.<br>Хууль зүйн зөвлөгөөг эрхийн төрлөөр ангилж үзвэл:<br>1. Хөдөлмөрлөх эрх – 339<br>2. Хууль зүйн туслалцаа авах эрх – 248<br>3. Хүүхдийн эрх – 95<br>4. Шударга шүүхээр шүүлгэх эрх – 80<br>5. Халдашгүй чөлөөтэй байх эрх – 74<br>6. Өмчлөх эрх – 51<br>7. Жендэрийн эрх тэгш байдал – 47<br>8.Төрийн албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрх – 45<br>9. Нийгмийн халамж хүртэх эрх – 29<br>10. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх – 21<br>11. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх -16<br>12. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх – 16<br>13. Хүчирхийллээс ангид байх эрх – 15<br>14. Сурч боловсрох эрх – 12<br>15. Эрүү шүүлтээс ангид байх эрх – 12<br>16. Мэдээлэл авах эрх – 5<br>17. Шашин шүтэх, эс шүтэх эрх – 4<br>18. Амьд явах эрх – 4<br>19. Хохирол нөхөн төлүүлэх эрх – 4<br>20. Чөлөөтэй зорчих эрх – 3<br>21. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх – 3<br>22. Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх – 1<br>23. Иргэний харьяалалтай байх эрх – 1<br>24. Оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх – 1 | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 25. Зохистой орон байраар хангагдах эрх – 1 | |
| 3.1.4 | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх;<br><br><u>Хэрэгжилт= Хүрсэн түвшин-Суурь түвшин</u><br>Зорилтот түвшин-Суурь түвшин * 100% аргыг ашигласан.<br>904-1146= -242<br>1250-1146=346<br>242/346=0.699*100=69.9% | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд, хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрлэсэн эсэх<br><br>ГМШХ | 1146 | 1250 | Тайлант хугацаанд 904 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 230 буюу 25.4 хувийг орон нутгаас ирүүлсэн гомдол байна.<br>Дээрх гомдлын 185 буюу 20.5 хувийг цахимаар, 704 буюу 77.9 хувийг бичгээр, 13 буюу 1.4 хувийг утсаар, 2 буюу 0.2 хувийг амаар ирүүлсэн байна.<br>Гомдол илгээгчийн төрлөөр ангилбал иргэн 820 буюу 90.7 хувь, төлөөлж гаргасан гомдол 49 буюу 5.4 хувь, хамтран гаргасан гомдол 35 буюу 3.9 хувийг эзэлж байна.<br>Тайлант хугацаанд нийт 790 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэсэн хэлбэрээр ангилбал:<br>1. Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар өөрт нь тайлбарлаж хариу өгсөн – 196<br>2. Харьяалалын дагуу холбогдох байгууллагад шилжүүлсэн – 184<br>3. Комиссын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу хариу өгсөн – 91<br>4. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдлыг шалгуулахаар шилжүүлсэн – 77<br>5. Зөвлөгөө өгсөн – 64<br>6. Хяналт шалгалт хийсэн – 37<br>7. Зөвлөмж хүргүүлсэн – 35<br>8. Шаардлага хүргүүлсэн – 33<br>9. Гомдлоосоо татгалзсан – 32<br>10. Гомдлын шаардлага хангаагүй гомдлыг буцаасан – 25<br>11. Эвлэрүүлсэн – 13<br>12. Төлөөлөн нэхэмжлэл гаргахаар шийдвэрлэсэн – 2<br>13. Гомдол гаргагч нас барсан – 1 | Үнэлгээ 70% |
| 3.1.5 | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах; | Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, хохирол нөхөн төлүүлэхээр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо<br><br>ГМШХ | 2 | 3 | Иргэн Н-ийн гаргасан гомдлын мөрөөр түүнийг төлөөлөн гаргах нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангах, ирүүлсэн баримт материалд дүн шинжилгээ хийх, нотлох баримтын шаардлага хангуулах ажил хийгдэж байна. Мөн иргэн Д, А нарын гомдлын дагуу холбогдох баримт, материал гаргуулан авах ажиллагаа хийгдэж байна. | Үнэлгээ-0% |
| 3.1.6 | Комиссын гишүүний шаардлага хүргүүлэх; | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байгууллага, | 43 | 53 | Комиссын гишүүний 25 шаардлага боловсруулж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. | Үнэлгээ 50% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага хүргүүлсэн эсэх<br><br>ГМШХ СДШХШХ, ХЭХХ | | | | |
| 3.1.7 | Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлэх; | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага хүргүүлсэн эсэх<br><br>ГМШХ СДШХШХ, ХЭХХ, ХМХХ | 57 | 67 | Комиссын гишүүний 45 зөвлөмж боловсруулж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. | Үнэлгээ 70% |
| 3.1.8 | Гомдол, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийх; | Хяналт, шалгалт хийсэн байх<br><br>ГМШХ | 53 | 55 | Гомдол мэдээллийн мөрөөр 31, Комиссын гишүүний санаачилгаар 119, төслийн хүрээнд 35, албан тушаалтны хүсэлтээр 1, мэдээллийн мөрөөр 1 нийт 187 хяналт шалгалт хийгдсэн. Үүнд:<br>1. Комиссын даргын- 82<br>2. Комиссын гишүүдийн 105 | Үнэлгээ- 100% |
| 3.1.9 | Гишүүний санаачилгаар хяналт шалгалт хийх; | Хяналт, шалгалт хийсэн байх<br><br>СДШХШХ | 53 | 55 | Комиссын дарга, гишүүдийн баталсан удирдамжийн дагуу Хөвсгөл, Булган, Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулиуд болон дотуур байр, Төв аймгийн Ерөнхий боловсролын "Хүмүүн" цогцолбор сургуулийн дэргэдэх дотуур байр, хүүхдийн асрамжийн төвүүд, Ховд аймгийн Хөгжимт драмын театр, Говь-Алтай аймгийн Зооноз өвчин судлалын төв, Гандантэгчэнлин хийд, “Таван толгой түлш” ХХК-ийн Баруун бүсийн үйлдвэр, Иргэний нисэхийн ерөнхий газар, дүүргүүдийн ТҮГ-ууд, Төмөр замын дээд сургууль, цэргийн анги, зарим сумын ЗДТГазрын үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалт хийсэн. | Үнэлгээ- 100% |
| 3.1.10 | Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөнтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, ажиллагаа хийх, дүгнэлт гаргах | Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөнтэй холбоотой дүгнэлт гарсан байна. | 0 | 2 | Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөнтэй холбоотой 20 гомдол, мэдээлэл ирснээс 17 гомдол, мэдээллийг шийдвэрлэж Комиссын гишүүний 3 зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн.<br>3 гомдол ажиллагаанд байна. | Үнэлгээ- 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | ХЭХХ | | | | |
| 3.1.11 | Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөнтэй холбоотой баримтжуулалт хийх | Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөнтэй холбоотой баримтжуулалтыг хийсэн байна.<br><br>ХЭХХ | 0 | 50% | “Хүний эрх хамгаалагч Хүчирхэг залуус” ТТБ-тай хамтран Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх баримтжуулалтыг хийсэн. | Үнэлгээ-100% |
| 3.1.12 | Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх | Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаар гомдол, мэдээллийн санг бүрдүүлсэн байна.<br><br>ХЭХХ | 0 | 50% | Хүний эрх хамгаалагчийн хэлтэст ирсэн 20 гомдол мэдээллийг бүртгэж, цахим мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. | Үнэлгээ-100% |
| Зорилт 3.2 | | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бэхжүүлэх | | | | |
| 3.2.1 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн хэлтсийг Комиссын Тамгын газарт байгуулж, хүний нөөц, орон байр, бусад материаллаг нөхцөлөөр хангах; | Ажиллах, орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна.<br><br>ЗУХ | 0 | 100% | УИХ-ын 2022 оны 29 дүгээр тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэнг томилсон ба Тамгын газраас шинээр томилогдсон гишүүний ажиллах нөхцөл, орчинг бүрдүүлж шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан. Комиссын даргын 2022 оны А/21 дүгээр тушаалаар тус хэлтсийн бүтэц, орон тоог баталж холбогдох албан тушаалын тодорхойлолтуудыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулсан. | Үнэлгээ-100% |
| 3.2.2 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн, хэлтсийн ажилтнуудыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколоор Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх чадавхыг бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулах; | Чадавх бэхжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.<br><br>Тамгын газар | 0 | 100% | Цар тахлын улмаас хойшилж байсан UPR Trust Fund-ийн санхүүжилттэй төслийн ЭШУСМ-тай холбоотой бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг дахин идэвхжүүлэх асуудлаар ГХЯ, НҮБСЗГ, НҮБХЭДКГ-тай цахим уулзалт хийж, 10 дугаар сард төслийн санал боловсруулж ГХЯ-нд хүргүүлсэн. | Үнэлгээ-0% |
| Зорилт 3.3 | | Хүний эрх хамгаалагчийг хамгаалах үндэсний механизмыг бий болгож, бэхжүүлэх | | | | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 3.3.1 | Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг сонгон шалгаруулж, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хуульчид, хүний эрхийн хамгаалагчдаас бүрдсэн Хороо байгуулах; | Хүний эрх хамгаалагчийн хороо байгуулагдсан байна. ХЭХХ | 0 | 100% | Комиссын 2022.06.03-ны өдрийн ээлжит бус 06 дугаар хуралдаанаар Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Комиссын гишүүдийн нууц санал хураалтаар олонхын санал авсан С.Дондов гишүүнийг Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнээр сонгосон.<br>Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу ХЭҮК, ХЗДХЯ, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.<br>Хүний эрх хамгаалагчийн хорооны ажиллах журмыг батлуулж, ХЭҮК-ын дэргэд Хүний эрх хамгаалагчийн Хороог байгуулсан. | Үнэлгээ-80% |
| 3.3.2 | Хүний эрхийг хамгаалагчийн асуудал эрхэлсэн хэлтсийг Комиссын Тамгын газарт байгуулж, хүний нөөц, орон байр, бусад материаллаг нөхцөлөөр хангах; | Ажиллах, орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна. ЗУХ | 0 | 100% | УИХ-ын 2022 оны 28 дугаар тогтоолоор ХЭҮК-ын гишүүнээр С.Дондовыг томилсон ба Тамгын газрын зүгээс шинээр томилогдсон гишүүний ажиллах орчинг нөхцлийг бүрдүүлж шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2022 оны А/13 дугаар тушаалаар Тамгын газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулж, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн орон тоог баталж албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулсан. | Үнэлгээ-100% |
| 3.3.3 | НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал болон Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах; | Сурталчилгаа, нөлөөллийн ажил хийсэн байна. ХЭХХ | 0 | 100% | НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хүний эрх хамгаалагчийн хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 44 постер, 23 видео шторк, 2 брошур, гишүүний 2 уриалгыг тус тус боловсруулсан. Мөн олон нийтийг хамарсан өдөрлөгт оролцож зөвлөгөө мэдээлэл өгч, сурталчлан таниулж ажилласан.<br>Сургалт, сурталчилгаатай холбоотой цахим мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. | Үнэлгээ-100% |
| 3.3.4 | Хүний амь нас, эрүүл мэнд нь бодитой, ноцтой эрсдэлд орсон хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах шуурхай ажиллагааны горим тогтоох; | Горим тогтоосон байна. ХЭХХ | 0 | 50% | Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудтай санал солилцох уулзалтыг зохион байгуулан хүний амь нас, эрүүл мэнд нь бодитой, ноцтой эрсдэлд орсон хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах шуурхай ажиллагааны горим тогтоох талаар харилцан тохиролцсон. | Үнэлгээ-80% |
| 3.3.5 | Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагалдан гарах журмуудыг боловсруулж, батлуулах | Холбогдох журмуудыг боловсруулсан байна. | 0 | 100% | Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагалдан гарсан дараах журмуудыг баталсан. Үүнд:<br>-“Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ыг ХЭҮК-ын даргын 2022 оны А/26, “Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүнд урамшуулал олгох журам”-ыг А/45, “Хүний эрх | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | - Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журам<br>- Хүний эрх хамгаалагчийн хорооны ажиллах журам<br>- Хүний эрх хамгаалагчийн хорооны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, дүгнэлт гаргах журам<br>- Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүнд урамшуулал олгох журам | ХЭХХ | | | хамгаалагчийн хорооны ажиллах журам", "Хүний эрх хамгаалагчийн хорооны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал", "Аюулын зэрэг тогтоох аргачлал"-ыг А/46 дугаар тушаалаар тус тус баталсан. | |
| 3.3.6 | Аймаг орон нутагт хүний эрх хамгаалагчийн үндэсний тогтолцооны талаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br>ХЭХХ | 0 | 3 | "Хүний эрх хамгаалагчийн тогтолцоо" сэдвээр Дундговь аймагт 25, Дорноговь аймагт-19 иргэнийг хамруулсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. | Үнэлгээ-100% |
| 3.3.7 | Хүний эрх хамгаалагчийн асуудлаар сургалт хийх | Сургалт хийсэн байна.<br>ХЭХХ | 0 | 10 | Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчлан таниулах, мэдлэг олгох зорилгоор нийт 16 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 42.368 иргэнийг хамруулсан. Үүнээс 15 аймгийн 256 сумын 41.902 иргэнд 2 удаа, Нийслэл Улаанбаатар хотод нийт 14 удаагийн сургалтад 466 иргэнийг тус тус хамруулсан байна. Мөн сургалт, сурталчилгаатай холбоотой цахим мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. | Үнэлгээ-100% |
| 3.3.8 | Комиссын орон нутгийн ажилтнууд, хуульчид, өмгөөлөгчдийг хүний эрхийн сургагч багшаар бэлтгэх ажлыг зохион байгуулах. | Хүний эрх хамгаалагчийн сургагч багш нарыг бэлтгэсэн байна.<br>ХЭССХ<br>ХЭХХ | 0 | 1 | Монголын хуульчдын холбоо болон "Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн" ТББ-тай хамтран Хүний эрх хамгаалагчийг бэлтгэх сургагч багшийн сургалтад нийслэл болон орон нутгийн хэмжээнд нийт 150 хуульч, өмгөөлөгчдийг хамруулж гэрчилгээ олгов. | Үнэлгээ-100% |
| 3.3.9 | Хүний эрх хамгаалагчийн асуудлаар иргэний нийгэм, үйлдвэрчний эвлэл, намын төлөөлөл, малчид зэрэг бүлгүүдтэй уулзалт, хийх | Уулзалт хийж, хамтын ажиллагааны чиглэлээ тогтсон байна. | 0 | 4 | Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийг сурталчлах, таниулах, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хүний эрх хамгаалагчийг хүндлэн, хамгаалах талаар цагдаа, сэтгүүлч, улс төрийн намын төлөөлөл, шүүгч, прокурор, иргэний нийгмийн | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | ХЭХХ | | | байгууллагын төлөөлөл, өмгөөлөгч, малчид, үйлдвэрчний эвлэлийн холбоод зэрэг 10 орчим бүлгүүдтэй уулзалт зохион байгуулсан.<br>Мөн "Улс төрийн хүрээний жендэрийн тэгш байдал ба хүний эрх", "Хүний эрх ба хүний эрх хамгаалагчийн тогтолцоо" сэдвийн хүрээнд улс төрийн намуудтай хамтран Хүний эрх хамгаалагчийг бэлтгэх сургагч багшийн сургалтыг 15 аймгийн 256 суманд зохион байгуулж, давхардсан тоогоор 41902 иргэнийг хамруулаад байна. | |
| Стратегийн зорилго 4: Хүний эрхийн соёл, боловсролын үндэсний тогтолцоог бэхжүүлэх; | | | | | | |
| Зорилт 4.1 | | Бүх нийтийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах | | | | |
| 4.1.1 | Хүний эрхийн онол, эрх зүйн хэм хэмжээ, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, олон улсын механизмын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх механизмыг боловсронгуй болгох нь судалгаа хийх /кейсд тулгуурласан/ | Сургалт нөлөөллийн ажиллагаа зохион байгуулсан байна.<br><br>СДШХШХ, ХЭССХ | 0 | 100% | НҮБХХ-ийн Бизнес ба хүний эрх төсөлтэй хамтран төрийн болон ТББ-ын төлөөллийг оролцуулан "Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх нь" "Зөрчигдсөн эрхийг сэргээх арга зам" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг 2022 оны 2, 3 дугаар саруудад зохион байгуулсан. Мөн Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, УИХ-ын Тамгын газар, УЕП-ын дэргэдэх сургалт судалгааны хүрээлэн, төвийн удирдлагыг оролцуулан уулзалт зохион байгуулсан.<br>МҮЭХ-той хамтран "Үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтны хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа" сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд нийт 65 хүн хамрагдсан. | Үнэлгээ-100% |
| 4.1.2 | Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн зохицуулалтын агуулга, мөн чанарыг ойлгуулахад чиглэсэн сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагаа зохион байгуулах | Сургалт нөлөөллийн ажиллагаа зохион байгуулсан байна.<br><br>ХЭССХ | 0 | 100% | Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албаны үйл ажиллагаа, хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ, Төрийн үүрэг ба үйлчилгээ, Хүний эрхийн хязгаарлалт зэрэг сэдвийн агуулгад хүний эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн агуулга, мөн чанар тухай бүр тусгаж, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтад 4699 оролцогчийг хамруулсан.<br>Мөн 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхэлсэн жагсал цуглаан үед хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн агуулга бүхий 12 постер, уриалга гарган олон нийтэд түгээв. | Үнэлгээ-100% |
| 4.1.3 | Монголын Хуульчдын холбоогоор магадлан итгэмжлэгдсэн хичээлүүдийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах | Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна.<br><br>ХЭССХ | 0 | 100% | Монголын Хуульчдын холбоогоор магадлан итгэмжлэгдсэн хичээлүүдийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд "Шударга шүүхээр шүүлгэх эрх", "Нийтийн ашиг сонирхолыг шүүхээр хамгаалах" нь сэдвийг боловсруулсан байдлаар хүлээн авсан. | Үнэлгээ-50% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.4 | Эмч, эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан багц цаг олгох сургалтын хөтөлбөрийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр магадлан итгэмжлүүлэх; | Магадлан итгэмжлэгдсэн байна.<br>ХЭССХ | 0 | 100% | Эмч, эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан багц цаг олгох сургалтын хөтөлбөрийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр магадлан итгэмжлүүлж Багц цагийн сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллагын жагсаалтад бүртгэгдсэн. | Үнэлгээ-100% |
| 4.1.5 | Хөдөлмөрлөх эрхийн салбарын судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн эрхийг хангах тогтолцоог сайжруулах үе шаттай үйл ажиллагаа хийх; | Нөлөөллийн ажиллагаа хийгдсэн байна.<br>ХЭССХ, СДШХШХ | 30% | 50% | “Төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал” судалгааны ажлыг Хууль зүйн Үндэсний Хүрээлэнгийн судлаачдын багаар, “Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал” судалгааны ажлыг “Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төв” ТББ-аар гүйцэтгүүлж, судалгааны ажлын тайланг хүлээн авч, хийж дуусгасан.<br>ОУХБ-ын Европын холбооны санхүүжилт, "Зохистой хөдөлмөр ба худалдаа" төслийн дэмжлэгтэйгээр Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа, Ажлын байрны дарамт, хүчирхийллийн судалгааг 2021 онд гүйцэтгүүлсэн бөгөөд судалгааны талаарх хэлэлцүүлгийг 2022 оны 01 дүгээр сард зохион байгуулсан.<br>Эдгээр судалгааг хэвлэмэл бүтээл болгохоор ОУХБ-ын өгсөн зөвлөмжийн дагуу эцэслэн боловсруулж хүргүүлэв.<br>Мөн Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгааны хүрээнд гаргасан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл”-ийг тодорхойлсныг ОУХБ-ын экспертүүд судалж, судалгааны үр дүн, гаргасан саналыг танилцуулсан. | Үнэлгээ-100% |
| 4.1.6 | www.e-khutuch.mn цахим хуудсанд “Хүний эрх" сэдэв нэмж Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим хуудсыг холбох, хүний эрхтэй холбоотой видео шторк, контент, сурталчилгааны хуудас болон мэдээллийг тогтмол оруулах | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө<br>ХЭССХ | 0 | 100% | E-khutuch.mn дээрх Хүний эрхийн Үндэсний Комиссын танилцуулга мэдээллийг шинэчлэн хүргүүлсэн. | Үнэлгээ-80% |
| 4.1.7 | “Эрх зүйн хөтөч" бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Хүний эрхийн ойлголт", "Хүний эрхэд суурилсан хандлага”, “Хүний | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх | 0 | 100% | “Эрх зүйн хөтөч" бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Хүний эрхийн ойлголт", "Хүний эрхэд суурилсан хандлага”, “Хүний эрхийн зөрчлийг бусад эрх зүйн зөрчлөөс ялгаж таних нь” “Жендэр ба хүний эрх" гэсэн сэдвийн хүрээнд бичлэг хийлгэх, бичлэгт ашиглах мэдээлэл | Үнэлгээ-50% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | эрхийн зөрчлийг бусад эрх зүйн зөрчлөөс ялгаж таних нь" "Жендэр ба хүний эрх" зэрэг дөрвөн сэдвийг тусган батлуулах | үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө<br><br>ХЭССХ | | | боловсруулан, тайлан бэлтгэж Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | |
| Зорилт 4.2 | | Албан болон албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг дэмжих | | | | |
| 4.2.1 | Албан боловсролын бүх шатны сургалтын хөтөлбөрт хүний эрхийн мэдлэг олгох агуулгыг зарим хичээлийн онцлогтой уялдуулан сургалтын модулыг шинэчлэх | Сургалтын 2-4 модуль боловсруулж, сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх судалгааг эхэлсэн байна.<br><br>ХЭССХ | 0 | 100% | Хүний эрхийн сургагч багшийн 18 гарын авлагын сайжруулалтыг хийж нэгтгэн дүгнэж, илтгэх хуудас боловсруулав.<br>"Эрүүл мэндээ хамгаалуулах эрх", "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх" сэдвээр боловсруулсан гарын авлагад сайжруулалт хийсэн. | Үнэлгээ-90% |
| 4.2.2 | "Жагсаал, цуглааны үеийн хууль сахиулах ажиллагаа ба хүний эрх: алба хаагчдыг чадавхжуулах нь" модулыг боловсруулах | Сургалтын модуль боловсруулсан байна.<br><br>ХЭССХ | 0 | 100% | Монголын Эмнести интернэйшнл ТББ-тай хамтран "Жагсаал, цуглааны үеийн хууль сахиулах ажиллагаа ба хүний эрх: алба хаагчдыг чадавхжуулах нь" төслийг хэрэгжүүлж "Жагсаал, цуглааны үед хүний эрхийг дээдлэн хэв журам сахиулах" гарын авлагыг орчуулах, найруулан боловсруулах ажлыг ЦЕГ-тай хамтран ажиллаж бэлэн болгосон. | Үнэлгээ-90% |
| 4.2.5 | Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавхжуулах төслийг хэрэгжүүлж, хүний эрхийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах. | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.<br><br>Төслийн баг | 50% | 100% | Туслах малчдад зориулан хүний эрхийн 8 сэдэвт комик гарын авлагыг бэлтгэж, 200 хувь хэвлүүлсэн. Уг комикыг анимейшн болгож МҮОНТВ, Малчин ТВ-ээр олон нийтэд хүргэсэн.<br>Мөн төслийн ажлын гүйцэтгэлийн тайланг боловсруулж, "Туслах малчдын нийгэм, эдийн засгийн байдал хүний эрхийн хэрэгжилт судалгааны тайлан"-г эцэслэн хянаж, товхимол болгон 500 хувь хэвлүүлсэн. | Үнэлгээ-100% |
| 4.2.6 | Ажлын байрны дарамт хүчирхийллийн эсрэг сургалтын модулыг шинээр боловсруулах; | Сургалтын модуль боловсруулсан байна.<br><br>ХЭССХ | 0 | 100% | Хөдөлмөрийн хүрээний дарамт, хүчирхийлэл судалгааны тайланд үндэслэн сургалтын модуль боловсруулах танилцуулга, төсвийн задаргааг гарган ОУХБ-д хүргүүлэв. Сургалтын модулыг боловсруулах ажлын даалгавар боловсруулж ОУХБ-руу илгээсэн боловч ОУХБ-аас энэ жил санхүүжүүлэлт байхгүй тул 2023 онд хийхээр хойшлуулсан. | Үнэлгээ-0% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 4.2.7 | Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд хохирсон гэмт хэргийг мөрдөх аргачлал боловсруулах, сургалтыг модуль боловсруулах, сургалт зохион байгуулах | Сургалтын модуль боловсруулж, сургалт хийсэн байна. ХЭССХ | 0 | 100% | "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь" цагдаагийн алба хаагчдад зориулсан гарын авлага боловсруулах, “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх зүйн байдлын талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх" судлаач, зөвлөхүүдтэй гэрээ байгуулж, ажлын уялдаа холбоо, зохицуулалтыг хангаж ажилласан.<br>2022.04.08-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн алба хаагчдад тус гарын авлагаар санал авах хэлэлцүүлэг-сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус ажлын хүрээнд төсөв гаргах, Холидэй Инн УБ-тай гэрээ байгуулах, оролцогчид урих тухай албан бичиг төлөвлөх зэрэг зохицуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.<br>Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн санаачилгаар “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь” сэдэвт цагдаагийн алба хаагчдад зориулсан гарын авлага, “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ”-г боловсруулан 3200 хувь хэвлүүлж хэвлүүлж жагсаалтын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлэв.<br>Уг гарын авлагад үндэслэн Улаанбаатар хот, Дундговь, Орхон, Сүхбаатар, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Говь-Алтай аймаг дахь мөрдөн шалгах тасгийн дарга, мөрдөгчид, хүүхдийн асуудал хариуцсан 120 алба хаагчдад бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх, алба хаагчдыг хохирогч төвтэй хандлагад суралцуулах, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлогийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. | Үнэлгээ-100% |
| 4.2.8 | Хүний эрхийн сургалт зохион байгуулах | Хүний эрхийн боловсролын цахим санд бүртгэгдсэн сургалтын тоо ХЭССХ | 64 | 70 | Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхийн боловсрол олгох 768 удаагийн сургалтад 2236 цагийн 54561 оролцогчийг хамруулсан байна. Үүнээс Нийслэлд нийт 132 удаагийн 482,5 цагийн 14402 оролцогчийг хамруулан сургалт зохион байгуулав. Орон нутагт 636 удаагийн 1753,5 цагийн 40159 оролцогчийг хамруулан зохион байгуулсан байна. | Бодит тоо мөн эсэх<br>Үнэлгээ-100% |
| 4.2.9 | Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо | 0 | 3 | 1. Архангай аймгийн "Тэгш тусгал" ТББ-ын орон нутгийн гишүүдэд зориулсан хүний эрхийн сургагч багш бэлтгэх ээлжит | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | ХЭССХ | | | сургалтыг 2 дахь удаагаа 2022.04.18-22-ны өдрүүдэд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд зохион байгуулсан. Тус сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, төрийн байгууллагуудын төлөөлөл нийт 35 ажилтан хамрагдсан.<br>2. Цагдаагийн байгууллагын алба хаагчдад зориулсан "Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт"-ыг 2022 оны 11 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгууллаа.<br>Уг сургалтад ЦЕГ-ын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар, Хар тамхитай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Дотоодын цэргийн 05 дугаар анги болон нийслэл, дүүргийн цагдаагийн 30 алба хаагч хамрагдаж тэдэнд гэрчилгээ олгов.<br>Сургалтад хамрагдсан алба хаагч нарыг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар "сургагч багш"-аар томилж, өөрийн анги, байгууллагадаа сургалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, төлөвлөгөөг батлуулан биелэлт, үр дүнг нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-950 зааснаар хагас, бүтэн жилээр цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв үнэлж, дүгнэн танилцуулга нотломжийн хамт Цагдаагийн ерөнхий газрын даргад болон Хүний эрхийн Үндэсний Комиссд жил бүр биелэлтийг хүргүүлж ажиллана.<br><br>Мөн сургагч багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, байгууллагын зүгээс гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сургалтыг ажлын үзүүлэлт болгон оруулан, үр дүнг дүгнэж байхаар Цагдаагийн ерөнхий газрын дарга Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт үүрэг, чиглэл өгсөн байна.<br>Сургагч багшийн сургалт зохион байгуулахтай холбоотой сургалтын танхим авах албан бичиг боловсруулах, өдрийн цайны завсарлагаа, гэрээ байгуулах, ирц бүртгэх, оролцоог хангах, сургагч багш нарыг олох зэрэг ажлыг хариуцаж гүйцэтгэв. Сургалтын үнэлгээний хуудсыг нэгтгэн, илтгэх хуудас боловсруулан санхүүд хүлээлгэн өгсөн. | Үнэлгээ-100% |
| 4.2.10 | "Хүний эрхийн тухай ярилцъя" уулзалт, хэлэлцүүлгийн сэдэв, оролцогчдын талаар ННФ-тай харилцан тохиролцож, зохион байгуулах | Улирал тутам зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо<br><br>ХЭССХ | 0 | 10 | ХЭҮК-оос Нээлттэй нийгэм форумтай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд 3 чиглэлийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Сэлэнгэ, Дорнод, Ховд, Орхон, Өмнөговь аймагт "Хүний эрх ба жендэр" бүсчилсэн сургалтын хүрээнд аймгуудын удирдлагуудтай орон нутгийн хүний эрхийн анхаарал татсан асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх боломж, гарцын талаар мэдээлэл, санал солилцох, зөвлөлдөх зорилгоор " | Үнэлгээ-70% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Хүний эрхийн тухай ярилцъя” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж Комиссын цахим хуудсаар шууд дамжуулалт хийсэн. Мөн “Маргаашийн Монголын дүр төрх-өнөөгийн залуусын нөхцөл байдал” сэдвээр 2022.05.27-ны өдөр Улаанбаатар хотод хийж шууд дамжуулалт хийсэн.<br>2. Хүний эрхийн ТВ ток шоу зохион байгуулах ажлын хүрээнд:<br>Нээлттэй нийгэм форум, МҮОНРТ-ийн төлөөлөлтэй 2022.05.05-ны өдөр уулзалт зохион байгуулж, "Цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх" сэдэвт телевизийн нэвтрүүлэг хийхээр харилцан тохиролцож, дараах ажлуудыг хийлээ. Үүнд:<br>- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ЦХАХ-ний судалгаа авахаар албан бичиг хүргүүлэх, тоон мэдээлэлд анализ дүгнэлт хийх;<br>- ХЭҮК-т цагдан хорих арга хэмжээтэй холбоотой ирсэн гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, уулзалтын тэмдэглэлийн жагсаалтыг гаргах, холбогдолтой кэйс тохиолдлыг зохиолын зураглалд оруулах;<br>- 2022.05.18-ны өдөр цахимаар холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй уулзаж, нэвтрүүлгийн зохиолд оруулах агуулга, хөндөх асуудлыг нэгтгэх;<br>- Комиссын төлөөлөн нэхэмжлэл гаргасан жагсаалтаас холбогдох кэйсийг түүвэрлэх, зохиолын зураглалд оруулах;<br>- Үндэслэлгүй хоригдсон, өндөр барьцаа тогтоосон зэрэг кэйс тохиолдлыг Шүүх.мн цахим хуудаснаас түүвэрлэх, зохиолын төсөлд нэгтгэх;<br>- Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалтыг гарган, мэдээллүүдийг нэгтгэж, Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ ба хүний эрх сэдвийн зохиолын зураглалыг 6 дэд сэдвийн хүрээнд боловсруулж, холбогдох албан тушаалтанд танилцуулсан.<br>3. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэвтрүүлэг хийх ажлын хүрээнд Говь-Алтай, Ховд, Баянхонгор аймгийн ЕБС-ийн дотуур байрны зураг авах ажлын зохицуулалтыг хангаж ажилласан. | |
| 4.2.11 | Хүний эрхийн боловсрол олгох контентийн жагсаалт гарган бэлтгэж, нийгмийн сүлжээгээр түгээх | Бэлтгэсэн контентын тоо<br><br>ХЭССХ | 74 | 100 | Мэндчилгээ 6,  Постер 98, Баннер 12,<br>Таны хүний эрхийн боловсролд 17,<br>7 шторк нийгмийн сүлжээгээр түгээсэн. Ковид-19 цар тахлын үед шийдвэр гаргагчдад зориулсан 6 постер, 2 шторк тус тус бэлтгэж иргэд, олон нийтэд түгээв.<br>**ХЭҮК-ын фэйсбүүк хуудасны хандалт 2021 онд 41308, 2022 онд 74413 болж өссөн байна.**<br>2021 онд Комиссын FB page хуудсаар хүргэсэн мэдээ мэдээлэл, **452684** хүнд хүрсэн бол 2022 онд **616378** болж өссөн байна.<br>**ХЭҮК-ын YOUTUBE хуудас 2460 дагагчтай** | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **ХЭҮК-ын twitter хуудас 1535 дагагчтай**<br>**ХЭҮК-ын Instagram хуудсыг шинээр үүсгэн хөтөлж байна.**<br>**37 дагагчтай 25 post-той**<br>2. Тайван хуран чуулах эрх чөлөөний зарчмууд сурталчилгааны ажлын хүрээнд 15 постер, 90 секундын анимейшны ажлын даалгавар, гэрээг боловсруулж байгуулав. | |
| 4.2.12 | “Хүний эрх” эрдэм шинжилгээний сэтгүүл бэлтгэж, олон нийтэд түгээх | Сэтгүүлийг олон нийтэд хүргэсэн байна.<br>ХЭБСХ | 2 | 4 | Сэтгүүлийн эхний улирлын дугаарын цахим эхийг бэлтгүүлж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан бөгөөд 500 ширхгийг хэвлүүлсэн.<br>Сэтгүүлд нийтлэл хүлээн авах зарыг постер хийн олон нийтийн сүлжээгээр түгээсэн байна. Хүний эрх сэтгүүлд ирсэн бүтээлүүдийг редакцын зөвлөлийн гишүүдэд илгээн хяналтын уншлага хийж байна.<br>Сэтгүүлийг 2023 оны 1 дүгээр сард гаргахаар төлөвлөж байна. | Үнэлгээ-60% |
| 4.2.13 | Хүний эрхийн олон улсын өдрийн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх; | Баталсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Тамгын газар | 0 | 1 | Хүний эрхийн Үндэсний форум 2022 арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдлын улмаас хойшлуулсан. | Үнэлгээ-50% |
| 4.2.14 | Хөгжлийн бэрхшээлтэй Монгол хүн нөлөөллийн ажлыг хийх | Нөлөөллийн ажлыг хийсэн байна.<br>ХЭССХ | - | 100 | Тэргэнцэртэй иргэдийн холбооноос боловсруулсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлууд" 5 сургалтын модуль гарын авлагад санал өгч ажилласан. Санхүүжилтийн улмаас 2023 онд хийхээр хойшилсон. | Үнэлгээ-30% |
| 4.2.15 | Урлагаар дамжуулж хүнлэг соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх | Хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн байна.<br>ХЭССХ | - | 100 | Урлагаар дамжуулж хүнлэг соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх ажлын хүрээнд:<br>Залуучуудад тулгамдсан хүний эрхийн асуудлаар контент бэлтгэх талаар 2022.05.20-ны өдөр контент бүтээгчдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд контент бүтээгчдээс үнийн санал авч гүйцэтгэх ажлын зураглал гарган ажиллаж байна.<br>Фото зургийн үзэсгэлэн зохион байгуулах талаар зураг авах сайн дурын багийн залуучуудтай 2022.10.28-ны өдөр уулзалт зохион байгуулж, уулзалтаар 2023 оны төлөвлөгөөнд төлөвлөж үзэсгэлэнг цогц байдлаар зохион байгуулах талаар тохиров. | Үнэлгээ-70% |
| 4.2.16 | “Хүний эрх ба жагсаал цуглааны үед хууль сахиулах нь” цагдаагийн удирдах албан тушаалтан болон сургагч багшийн сургалтыг зохион байгуулах | Оролцоог хангаж ажилласан байна.<br>ГХАТ, ХЭССХ | 0 | 25 | ЕАБХАБ-ын АИХЭА-тай хамтран тус байгууллагын хоёр экспертийг урьж ирүүлэн, Цагдаагийн удирдах албан тушаалтан 18 хүн, ДХИХ-ийн тэнхимийн эрхлэгч 2 хүн, Комиссын нэгжийн дарга 2 хүнийг оролцуулан жагсаал цуглааны үеэр хууль сахиулахад удирдах албан тушаалтны үүргийн талаар, цагдаагийн сургагч багш 13 хүн, ДХИХ-ийн багш 2 хүн, Комиссын сургагч багш 2 хүн оролцуулан сургагч | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багшийн сургалтыг 9 дүгээр сарын 14-16, 19-24-ний өдрүүдэд тус тус амжилттай зохион байгуулж гэрчилгээ олгов. | |
| Стратегийн зорилго 5. Хүний эрхийн салбарт олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх | | | | | | |
| Зорилт 5.1 | | НҮБ-ын хүний эрхийн механизмтай ажиллах үндэсний чадавхыг бэхжүүлэх | | | | |
| 5.1.1 | Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, Засгийн газрын оновчтой бүтэц бий болгоход нөлөөллийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх; | Холбогдох байгуулагад тухай бүр санал өгсөн байна.<br><br>ГХАТ | 0 | 100% | Олон улсын олон талт гэрээнүүдийн хэрэгжилтийн байдлыг УИХ-ын байнгын хороодоор хэлэлцэхээр товын дагуу 2022.03.30-ны өдөр ХЗБХ-оор 4 гэрээний хэрэгжилтийн асуудлыг хэлэлцсэн хуралд Хэлтсийн дарга оролцсон бөгөөд цаашид хэлэлцэх Байнгын хороод болон хамаарах гэрээдийн хэрэгжилтийн асуудлаар хариуцсан яамдын бэлтгэл хангах асуудлаар 2022.04.04-ний өдөр цахим хурал хийхэд Хэлтсийн дарга Комиссыг төлөөлөн оролцсон бөгөөд 2022 оны 12 дугаар сар хүртэл дахин хурал зохион байгуулаагүй. | Үнэлгээ-100% |
| 5.1.2 | НҮБ-ын Хүний эрхийн хамгаалах тогтолцооны байгууллагуудтай хамтран ажиллах; | Мэдээлэл хүргүүлж хамтарч ажилласан байна.<br><br>ГХАТ | 0 | 100% | Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 10 дугаар тайланд холбогдох Комиссын хөндлөнгийн мэдээллийг Комиссын гишүүн Д.Сүнжидийн өгсөн чиглэлийн дагуу бэлтгэж хүргүүлэв. Тайлант хугацаанд мэдээлэл солилцоо яваагүй.<br>Хорооны 82 дугаар хуралдаан болон түүний өмнөх Ажлын хэсгийн хуралдаанд Комиссын төлөөлөл оролцох бэлтгэл ажлыг хангаж, Комиссын дарга Ж.Хунан болон Комиссын гишүүн Д.Сүнжид Хорооны хуралдаанд 2022 оны 6 дугаар сарын 20, 23, 24-ний өдрүүдэд оролцож мэдээлэл хийлээ. | Үнэлгээ-100% |
| Зорилт 5.2 | | Олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэглэх үндэсний чадавхыг бэхжүүлэх | | | | |
| 5.2.1 | НҮБ-ын хүний эрхийн механизмаас Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг Засгийн газрын байгууллагуудаас<br>НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан ерөнхий зөвлөмжийг орчуулах, практик хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; | Холбогдох байгууллагуудад зөвлөмжийг уламжилсан байна.<br><br>ГХАТ | 0 | 25% | НҮБ-ын Хүний эрхийн хорооны Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн тухай 2020 оны 37 дугаар ерөнхий тайлбар зөвлөмж (21 дүгээр зүйл)-ийг орчуулж, хяналт хийн Комиссын хэрэглээнд оруулав. НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооны 35 дугаар зөвлөмжийг орчуулж, хяналтад шилжүүлэв. | Үнэлгээ-50% |
| 5.2.2 | "Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулахад үр нөлөөтэй ярилцлага хийх тухай зарчим"-ыг хууль сахиулах байгууллагуудад нэвтрүүлэх | Нөлөөллийн аян зохион байгуулж Мендезийн зарчмыг цахим болон бусад хэлбэрээр түгээсэн байна.<br><br>ГХАТ | 0 | 100% | 2021 оны 12 дугаар сард Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хийсэн цахим уулзалтаар тохиролцсоны дагуу Медезийн зарчмыг Монгол Улсад сурталчилан таниулах, хууль сахиулах байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх асуудлаар хэрэгжүүлэх төслийн санал болон хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулан тус Нийгэмлэгт хүргүүлэв.<br>Мендезийн Зарчмыг Монгол хэл рүү орчуулж, хууль сахиулах байгууллагуудад танилцуулах бэлтгэл ажлыг хангав. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөн Комиссын дарга тэргүүтэй төлөөлөл Женев хотод 2022.06.23-нд тус нийгэмлэгтэй хийх уулзалтыг зохион байгуулав. | |
| Зорилт 5.3 | | Олон улсын болон бүс нутгийн түвшинд Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурь, оролцоог нэмэгдүүлэх | | | | |
| 5.3.1 | Бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагуудтай олон талт түншлэлийг хөгжүүлэх, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; | Оролцоог хангаж ажилласан байна.<br><br>ГХАТ | 0 | 25 | НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн химийн хорт бодис ба хүний эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчээс ирсэн асуулгыг бөглөж байна. Гишүүдэд танилцуулж, 3 дугаар сарын 7 гэхэд хүргүүлсэн байх ёстой.<br>- ОУХБ-тай Ялтны хөдөлмөрийн судалгааны хүрээнд ОУХБ-руу холбогдох судалгааны материалуудыг орчуулж хүргүүлсэн.<br>- Азийн санд холбогдох санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланг боловсруулж цаг тухайд нь хүргүүлсэн.<br>- Ази, номхон далайн бүсийн форумын Хүний эрхийн шинэ төсөл, төлөвлөлтийн менежер Фасоха Айшаттай онлайн (zoom)-р уулзалт хийж ХЭҮК-ийн алба хаагчдад ирэх 10 дугаар сард “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг Комиссын үйл ажиллагаанд интеграцчилах нь” дотоод сургалтыг НҮБ-ын хүн амын сан болон Ази, номхон далайн бүсийн форумын дэмжлэгтэйгээр хийх талаар санал солилцов.<br>- НҮБ-ын хүүхдийн сангаас санхүүжүүлэх “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг хамгаалах” талаар удирдамж боловсруулах төслийн саналыг орчуулав.<br>- Казахстан улсын Хүний эрхийн омбудсменд тус улсад суугаа Монгол Улсын иргэдийн эрхийг хамгаалах асуудлаар албан бичиг төлөвлөн хүргүүлэв.<br>- АНДЧ-ны Магадлан итгэмжлэх асуудлаарх сургалтын шинэ хөтөлбөрт 2 дугаар сарын 14-ний өдөр Комиссын зүгээс панел хэлэлцүүлэгт туршлага хуваалцаж оролцов.<br>- ОУХБ үйг орчуулж, ОУХБ-ын саналын дагуу засаж цагт нь хүргүүлсэн. 02 дугаар сарын 14-ний өдөр ээлжит санал солилцох цахим уулзалт ОУХБ-тай зохион байгуулж судалгааны арга зүйг эцэслэж цаашид гишүүн, алба хаагчид талбарт судалгаа хийх боломжтой болсон. Орчуулагчтай синхрон орчуулга хийлгэхээр холбогдож ажил гүйцэтгэх гэрээ байгуулж цахим уулзалтын дараа ажил дүгнэх акт бичсэн.<br>- НҮБ-ын СЗГ-тай хамтран НҮБ-ын ХЭДКГ-тай цахим уулзалт зохион байгуулж UPR Trust Fund-төслийн хүрээнд 2022 онд зохион байгуулах үйл ажиллагаатай холбогдуулан Комиссын шинээр томилогдох гишүүдийн сонгон шалгаруулах үйл явц болон Олон улсын гэрээний хэрэгжилтийг үнэлэх УИХ-ын Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, санал мэдээлэл солилцов.<br>- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр цахим шуудангаар харилцав. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Жагсаал, цуглааны үед хууль сахиулах гарын авлагыг орчуулж, сургалт зохион байгуулах нь чиглэлээр мэйлээр харилцаж, 5 дугаар сарын 23-ны өдөр цахим уулзалт зохион байгуулж, 9 дүгээр сард бэлтгэл ажлыг ханган зохион байгуулсан бөгөөд цаашид хамтран ажиллах асуудлаар цахим шуудангаар санал солилцов.<br>- ОУХБ-т ялтны хөдөлмөрын судалгааны тайлангийн засварыг хүргүүлэв.<br>- ОУХБ-тай судалгааны нэмэлтийн талаар мэдээлэл солилцож үйл ажиллагааны төлөвлөгөөг, төсвийн хамтаар хүргүүлэв.<br>- .“Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавхжуулах нь” төслийн үр дүнг танилцуулах уулзалт зохион байгуулахтай холбогдуулан урилга, хөтөлбөр орчуулгыг хийж, оролцох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.<br>- АНДЧ-тай харилцан тохирлцосны дагуу цахим шуудангаар харилцсаны үндсэнд 10 дугаар сарын 31-нээс 11 дүгээр сарын 2-ны өдрүүдэд Комисст зориулсан Дээд түвшний цахим диалогийг бэлтгэл ажлыг ханган зохион байгуулсан. | |
| 5.3.2 | Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны (ХЭҮБДХ) ээлжит хурапд Комиссын төлөөлөл оролцох; | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх<br>ГХАТ | 0 | Тийм | Комиссын дарга Ж.Хунан, Комиссын гишүүн Г.Нарантуяа, Д. Сүнжид нар тус хуралд оролцов. | Үнэлгээ-100% |
| 5.3.3 | Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы (АНДЧ) ээлжит 27 дугаар хуралд Комиссын төлөөлөл цахимаар оролцох; | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх<br>ГХАТ | 0 | Тийм | АНДЧ-ын ээлжит 27 дугаар хурал 2022.09.14, 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Уг хуралд Комиссын дарга Ж.Хунан АНДЧ-ны Удирдах Хорооны гишүүнд, Комиссын гишүүн Д.Сүнжид ХЭҮБДХ-ны Товчооны гишүүнд бүсийг төлөөлөх гишүүнд нэр дэвшигчийг тодруулах сонгуульд, Комиссын гишүүн Г.Нарантуяаг ХЭҮБДХ-ны МИДХ-нд АНДЧ-ныг төлөөлөн суух гишүүний нэр дэвшигчийн сонгуульд тус тус нэр дэвшүүлж өрсөлдүүлсэн бөгөөд Комиссын дарга Ж.Хунан АНДЧ-ны Удирдах Хорооны гишүүн бөгөөд дэд даргын сонгуульт албан тушаалд томилогдсон. | Үнэлгээ-100% |
| 5.3.4 | Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы Ажлын албаны дарга нарын | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд | 0 | Тийм | Тайлант хугацаанд энэ уулзалтын тов гараагүй. | Үнэлгээ-0% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох; | оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх<br>ГХАТ | | | | |
| 5.3.5 | Евразийн Омбудс байгууллагуудын Ээлжит хуралд Комиссын төлөөлөл оролцох; | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх<br>ГХАТ | 0 | Тийм | Комиссын гишүүн Б.Энхболд, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Эрдэнэтөгс нар ОХУ-ын Хүний эрхийн омбудсмений урилгаар Евразийн Омбудсмений Холбооны ээлжит хуралд 2022.11.14, 15-ны өдөр оролцов. | Үнэлгээ-100% |
| 5.3.6 | Хүний эрхийн чиглэлээр олон улсын хурал, сургалт семинарт ажилтнуудыг хамруулах бэлтгэл ажлыг хангах; | Бэлтгэл ажлыг хангаж, хугацаанд нь арга хэмжээнд хамрагдан илтгэх хуудас бичигдсэн эсэх<br>ГХАТ | 0 | Тийм | Тайлант хугацаанд хүний эрхийн чиглэлээр нийт 8 удаагийн олон улсын хурал, сургалт семинарт албан хаагчид хамрагдсан. Үүнд:<br>- Ази, номхон далайн бүсийн Чуулганаас зохион байгуулсан Гомдол, хяналт шалгалтын онлайн сургалтанд ахлах мэргэжилтэн Б.Болор;<br>- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон БНСУ-ын Статистикийн төвийн хамтарсан Ази, Номхон далайн орнуудын Гэмт хэрэг, эрүүгийн эрх зүйн байдлын статистикийн мэргэжлийн төв (CoE), мөн НҮБ-ын Ази, Номхон Далайн Статистикийн Хүрээлэн (SIAP)-ээс “Гэмт хэргийн статистикийг жендэрийн үүднээс судлах хоёр дахь удаагийн цахим сургалт”-ын төслийн зарын дагуу ХЭҮК-ийн зарим алба хаагчид бүртгүүлж хичээлдээ сууж байна.<br>- ЕАБХАБ болон ЕТХЭҮБС-нээс хамтран зохион байгуулсан ХЭҮБ-ын Академи ээлжит сургалтад хэлтсийн дарга Ө.Ундрах;<br>- ЕАБХАБ-аас 2022.09.05, 06-ны өдөр зохион байгуулагдсан ХЭҮБ-уудын удирдлагын дээд түвшний уулзалтад Комиссын дарга Ж.Хунан;<br>- Комиссын гишүүн Г.Нарантуяа Туркменистан улсын Омбудсений албанд чадавхийн үнэлгээ хийх АНДЧ, НҮБХХ-ийн төслийн хүрээнд 2022.10.01-нээс 15-ны өдөр ажилласан.<br>- Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг 11 дүгээр сарын 06-16-ны өдрүүдэд БНСУ-ын ХЭҮК-ын урилгаа ХЭҮБ-ын Түншлэл-2022 сургалтад оролцсон;<br>- Комиссын гишүүн Г.Нарантуяа Этиоф Улсын Аддис Абеба хотод даний Хүний эрхийн Хүрээлэнгийн урилгаар ХЭҮБ-уудын Дижитал Эвслийн “Хүний эрх ба технологийн холбогдолд ХЭҮБ-ын мандатыг | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрхэн хэрэгжүүлэх талаар харилцан суралцах нь” арга хэмжээнд 2022.11.27-ноос 12.02-ны өдрүүдэд оролцов.<br>- Комиссын гишүүн Х.Мөнхзул, Д.Сүнжид нар 2022.11.28-наас 12.05-ны өдрүүдэд ОУХБ-ын Ази Номхон далайн бүсийн жендэрийн академи сургалтад оролцов. | |
| 5.3.7 | Хүний эрхийн чиглэлээр төслийн 2 хүртэл санал боловсруулж санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх; | Төслийн санал боловсруулж тэтгэлэг олгогч байгууллагад хүргүүлсэн байна.<br>ГХАТ | 0 | 100% | ЕАБХАБ-ын АИХЭГ-аас гаргасан Тайван замаар цуглаан хийх асуудлаарх гарын авлагыг орчуулж, хууль сахиулагчдад сургалт зохион байгуулах төсөл хэрэгжүүлэх боломжийг төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жагсаалтын хамтаар мэйлээр хүргүүлж, цуврал цахим уулзалтын хүрээнд 9 дүгээр сард цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтан 20, сургагч багшаар мэргэших 15 алба хаагчийг хамруулан сургалт зохион байгуулахаар тохиролцлоо.<br>- Комиссын сэтгүүлчдийн клубээс ирүүлсэн төслийн саналын танилцуулгыг АНУ-ын элчин сайдын яамны сайтад зарласан цахим хаягаар орчуулан хүргүүлж, сөрөг хариу хүлээн авсан. | Үнэлгээ-100% |
| 5.3.8 | Комиссын дарга, гишүүдийн хамтрагч байгууллагуудтай хийх уулзалтыг зохион байгуулах; | Тэмдэглэл хөтөлж, гаргасан санал, шийдвэрийг баталгаажуулж хэрэгжилтийг хангасан байна.<br>ГХАТ | 0 | Тийм | Тайлант хугацаанд нийт 25 албан тушаалтан, байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан, оролцож тэмдэглэл хөтлөн шийдвэрийг баталгаажуулсан. | Үнэлгээ-100% |
| 5.3.9 | Иргэний нийгмийн зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулах; | Бэлтгэл ажлыг нь хангаж, хугацаанд нь зохион байгуулан, шийдвэрийг нь баталгаажуулсан хурлын тоо<br>ЗУХ | 0 | 4 | Комиссын даргын 2022.01.10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталж, Комиссын даргын 2022.05.17-ны өдрийн А/16 дугаар тушаалаар Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан. Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлд иргэний болон улс төрийн эрхээр мэргэшсэн 5, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхээр мэргэшсэн 5, бусад эрхээр мэргэшсэн 8 төлөөлөл байх юм.<br>Иргэний нийгмийн зөвлөл нь 2022.05.23 болон 10.12-ны өдөр 2 удаа уулзаж хуралдсан бөгөөд Комиссын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагаатай танилцах, улмаар Комисстой хамтран ажиллах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар хэлэлцсэн байна. | Үнэлгээ-70% |
| 5.3.10 | "ХЭҮК, ИНБ-уудын хамтын ажиллагаа" ээлжит уулзалтыг зохион байгуулах; | Бэлтгэл ажлыг нь хангаж, хугацаанд нь зохион байгуулсан уулзалтын тоо | 0 | 2 | Комиссоос жил болгон зохион байгуулдаг "ХЭҮК, ИНБ-уудын хамтын ажиллагаа" ээлжит 19 дэх уулзалтыг 2022.04.22-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг уулзалтаар Комиссын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцүүлж, Комиссоос | Үнэлгээ-70% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | ЗУХ | | | хэвлүүлсэн ном гарын авлагыг тараасан. Уг уулзалтаар иргэний нийгмийн байгууллагын 50 гаруй төлөөлөл оролцсон. | |
| 5.3.11 | Монгол Улс дахь олон улсын байгууллагуудтай Тогтвортой хөгжил-Хамтын ажиллагаа ээлжит уулзалтыг зохион байгуулах; | Бэлтгэл ажлыг хангаж, хугацаанд нь зохион байгуулсан уулзалтын тоо<br><br>ГХАТ | 0 | 2 | Уг уулзалт 2022.10.26-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд уулзалтад ОУХБ, Эмнести Интернешнл, АНУ-ын ЭСЯ, Ханнс Зайделийн Сангийн төлөөлөл оролцсон. Уулзалтаар Комиссын бүтэц бүрэлдэхүүн болон 2022 оны үйл ажиллагааны танилцуулга, 2023 онд зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл, хамтран ажиллаж болох чиглэлийн талаар санал солилцов. Үр дүнд нь Ханнс Зайделийн Сантай хийх үйл ажиллагааны талаар албан бичгээр санал боловсруулж хүргүүлсэн. | Үнэлгээ-70% |
| 5.3.12 | Орон нутгийн удирдлагуудтай хамтын ажиллагааны уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах; | Тухай бүр нь уулзалт зохион байгуулж, хамтран ажилласан байна.<br><br>ЗУХ | 0 | 10 | Тайлант хугацаанд Комиссын гишүүд 14 аймаг (Орхон, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Ховд, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Сүхбаатар, Дундговь, Баян-Өлгий, Завхан, Увс, Өмнөговь)-т ажиллаж, орон нутгийн удирдлагуудтай уулзаж, мэдээлэл солилцсон. Комиссын орон нутаг дахь албан хаагчид дээрх аймгуудын талаарх мэдээ мэдээллийг нэгтгэн гаргаж өгөх, аймгийн удирдлагууд болон хяналт шалгалт хийх байгууллагуудтай уулзалт товлож, удирдамж танилцуулж, зохион байгуулалтыг хангаж ажилласан. Түүнчлэн орон нутгийн 8 албан хаагч нийт 25 сумдад Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажиллаж, сумын удирдлагуудтай уулзаж, хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож ажилласан. Үүнд:<br>- Баян-Өлгий аймаг дахь ахлах шинжээч Л.Уранчимэг Баян-Өлгий аймгийн Улаан хус, Толбо, Дэлүүн, Булган сумд;<br>- Өмнөговь аймаг дахь референт Г.Нарангоо Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Баян-Овоо, Баяндалай сумд;<br>- Дорнод аймаг дахь референт Д.Дугарсүрэн Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баяндун, Сэргэлэн сумд;<br>- Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг Дундговь аймгийн Өндөршил, Гурвансайхан, Луус, Хулд сумд;<br>- Сэлэнгэ аймаг дахь ахлах шинжээч Д.Гантулга Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Сант, Орхон, Орхонтуул сумд;<br>- Увс аймаг дахь референт Я.Хонгорзул Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Баруунтуруун, Цагаанхайрхан сумд;<br>- Архангай аймаг дахь референт С.Мөнгөнзаяа Архангай аймгийн Өлзийт, Өгийнуур, Хашаат сумд | Үнэлгээ-100% |
| 5.3.13 | ОУБ-ын санхүүжилтээр хүний эрх хамгаалагчдад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй | 0 | 1 | Төслийн санал боловсруулан бусад төслийн бүрэлдэхүүн хэсэгтэй нэгтгэж, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын албанд явуулахаар ГХЯ-д цахим шуудангаар хүргүүлсэн. | Үнэлгээ-30% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлсэн байна.<br>ХЭХХ | | | | |
| 5.3.14 | Хүний эрх хамгаалагчийн асуудлаар олон улсын хэмжээний зөвлөлдөх уулзалт зохион байгуулах | Бэлтгэл ажлыг нь хангаж, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан байна.<br>ХЭХХ | 0 | 1 | ХЭҮК-ын дарга Ж.Хунангийн урилгаар “Хүний эрхийн Олон Улсын Үйлчилгээ” байгууллагын Нью Йорк хот дахь албаны захирал Тесс МакЭвой, хөтөлбөрийн менежер Аделайде Этонг Каме нар хүрэлцэн ирж 2022.09.26-наас 2022.09.29-ний өдрүүдэд Хүний эрх хамгаалагчдын чадавх бий болгох сургалт, лекцийг “Хүний эрх хамгаалагчийн тухай ойлголт”, “Марракешийн тунхаглал”, “НҮБ-ын Хүний эрх хамгаалагчийн талаарх тунхаглал, Жишиг хууль”, “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмууд”, “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх нь, ХЭҮК-ын гүйцэтгэх үүрэг” сэдвийн хүрээнд хууль сахиулах байгууллагын алба хаагч, цагдаагийн албан хаагч, хүний эрх хамгаалагч сургагч багш, сэтгүүлчдэд орсон. Сургалтад нийт 280 иргэн хамрагдсан.<br>Хүний эрхийн Олон Улсын Үйлчилгээ Байгууллагын Нью-Йорк хот дахь албаны захирал Тесс Макэвойт 2022.09.27-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатар, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан, 2022.09.29-ний өдөр УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Б.Энхбаяр, УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг нартай хийсэн уулзалтад ХЭҮК-ын дарга Ж.Хунан, ХЭҮК-ын гишүүн С.Дондов, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга З.Өнөржаргал, Гадаад хамтын ажиллагааны тасгийн дарга Ө.Ундрах нар оролцсон. | Үнэлгээ-100% |
| Стратегийн зорилго 6. Хүний эрхийн Үндэсний Комиссын чадавхыг бэхжүүлэх | | | | | | |
| Зорилт 6.1 | | Комисс нь иргэдэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй, хүрэлцээтэй үйл ажиллагаагаа явуулах байртай болох | | | | |
| 6.1.1 | Комиссын байр барих газар, хөрөнгийг шийдвэрлүүлэх нөлөөллийн ажиллагаа явуулах; | Комиссын байр барих газар, хөрөнгийг шийдвэрлүүлэх нөлөөллийн ажиллагаа хийгдсэн байна.<br>ЗУХ | 0 | 100% | Комиссын байр барих зориулалтаар Чингэлтэй дүүрэгт 2,7 га газрын асуудлыг шийдүүлсэн. | Үнэлгээ-50% |
| Зорилт 6.2 | | Хүний эрхийн хяналт, шалгалт, гомдол шийдвэрлэх, хүний эрхийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох | | | | |
| 6.2.1 | Гомдол шалгах, шийдвэрлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааны дотоод журмыг | Гарын авлага боловсруулж, | 40% | 100% | Журмын төслийг шинэчлэн боловсруулж Г.Нарантуяа гишүүнд 2022.05.16-ны өдөр танилцуулсан. Уг журмын шинэчлэлтэй холбоотойгоор Комиссын гишүүд болон ГХШХ-ийн ажилтнууд, бичиг | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэх, гомдол шалгах, хяналт шалгалт хийх гарын авлага боловсруулж, ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх; | хэрэгжүүлсэн байна. Журам шинэчлэгдэн батлагдсан байна. ГМШХ | | | хэргийн ажилтан оролцсон уулзалтыг 2022.05.27-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлсэн. Журмын төслийг эцэслэн боловсруулж Комиссын гишүүд болон Тамгын газрын даргаар хянуулж 2022.10.10-ны өдөр Комиссын даргад хүргүүлсэн. | |
| 6.2.2 | ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх; | Дүн шинжилгээ хийсэн байна. ГМШХ, СДШХШХ | 0 | 100% | ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж журмыг шинэчлэн боловсруулж батлуулахаар Комиссын даргад хүргүүлсэн. | Үнэлгээ-100% |
| 6.2.3 | Байгууллагын үйл ажиллагааны талаар статистик мэдээлэл гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх; | Нэгж тус бүрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд мэдээллийн сан бий болсон байна. Тамгын газар | 0 | 100% | Комиссын үйл ажиллагааны статистик мэдээллийг 6 удаа боловсруулж, байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст нийтэлж, олон нийтэд сурталчилсан. | Үнэлгээ-100% |
| Зорилт 6.3 | | Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны үр дүнтэй түншлэлийг бэхжүүлэх | | | | |
| 6.3.1 | Комиссоос хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах стратегийг боловсруулж хэрэгжүүлэх. | Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна. ХЭССХ | 0 | 100% | Комиссоос хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах стратегийг боловсруулах ажил дууссан. Комиссын дарга Ж.Хунан болон Комиссын гишүүд, Тамгын газрын даргад танилцуулахаар бэлдэж байна. | Үнэлгээ 100% |
| 6.3.2 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | Мэдээллээр хангасан иргэдийн тоо ХЭССХ | 10 | 20 | Тамгын газрын цахим хуудасны Ил тод байдлын хэсэгт Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, сул орон тооны захиалгатай холбоотой мэдээллийг байршуулсан.<br>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах мэдээллийг Комиссын хэлтсийн бүх дарга нарт 9 сараас эхлэн танилцуулсан. | Үнэлгээ-100% |
| 6.3.3 | Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, | Хэвлэлийн бага хурлын тоо, ярилцлагын тоо ХЭССХ | 2 | 65 | 1. Комиссын дарга болон гишүүд, алба хаагчид хэвлэл мэдээллийн нийт 31 байгууллагад давхардсан тоогоор 89 удаа ярилцлага өгсөн.<br>2. Комиссын сайтад нийт 87 мэдээ, мэдээлэл болон зар байршуулсан.<br>3. Комиссын пэйж хуудаст нийт 211 мэдээ болон зар, постер байршуулсан. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | ярилцлага өгөх ажлыг хэрэгжүүлэх | | | | | |
| 6.3.4 | “Хүний эрхийн төлөө” сэтгүүлчдийн клубын үйл ажиллагааг зохион байгуулна | Тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан уулзалтын тоо<br><br>ХЭССХ | 1 | 6 | Сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Тамгын газрын даргаар батлуулан 2022 оны 09, 10, 12 дугаар саруудад нийт 3 удаа сэтгүүлчдийн сургалт зохион байгуулсан. Сургалт, уулзалтад<br>1. ХЭҮК-ын гишүүн Х.Мөнхзул - “Ажлын байрны дарамт”,<br>2. ХЭҮК-ын гишүүн С.Дондов - “Сэтгүүлч нь хүний эрх хамгаалагч”,<br>3. ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”,<br>4. ХЭҮК-ын гишүүн Д.Сүнжид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль,<br>5. ХЭҮК-ын гишүүн Б.Энхболд Халдашгүй чөлөөтэй байх эрх ба дур зоргоор баривчлан саатуулах асуудал<br>6. Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн, “Глоб Интернэшнл” төвийн хуульч, өмгөөлөгч Б.Пүрэвсүрэн-“Гүтгэлэг”<br>7. ИНЗ-ийн гишүүн Д.Ардак "Сургуулийн орчин дахь хүчирхийллийг таслан зогсооё" сэдвээр хичээл заасан.<br>Сургалтад нийт давхардсан тоогоор нийт 35 хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийт 38 сэтгүүлч хамрагдсан. | Үнэлгээ-100% |
| Зорилт 6.4 | | Хүний эрхийн Үндэсний Комиссын материаллаг болон мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх | | | | |
| 6.4.1 | Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах; | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсан байна.<br><br>ЗУХ | 1 | 100% | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Цалин хөлс нэмэгдүүлэх чиглэлээр-Тамгын газрын даргын 2022.01.05-ны өдрийн А/01 дугаар тушаалаар хоол, унааны хөнгөлөлтийг нэмэгдүүлэн баталж, 02 дугаар тушаалаар нийт 42 төрийн захиргааны албан хаагч, төрийн үйлчилгээний 5 албан хаагчдын цалинг 2022.01.05-ны өдрөөс нэмж, 03 дугаар тушаалаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 11 албан хаагчид олгосон. Комиссын даргын 2022.02.18-ны өдрийн А/07 дугаар тушаалаар төрийн захиргааны 11 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан, 8 албан хаагчид шинээр зэрэг дэв олгосон. Түүнчлэн 1 албан хаагчид тэргүүн түшмэл, 3 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар холбогдох материалыг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд хүргэсэн. Шинээр томилогдсон 2 гишүүнд зэрэг дэв олгуулахаар МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газарт холбогдох баримтын хамт хүргүүлсэн.<br>2. Дотоод журамд заасан буцалтгүй тусламж олгох- Шинэ хүүхэд төрүүлсэн 8, нас барсны тэтгэмж 5, эмчилгээний зардал 2 албан хаагчид тус тус 500,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Түүнчлэн ердийн галлагаатай орон сууцанд амьдардаг 4 ажилтанд тус бүр 500,000, өрхийн орлого багатай, өрх толгойлсон 1 албан хаагчид 5,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж тус тус олгосон. Хууль яамны тэргүүний ажилтнаар 3, Хүндэт жуух бичгээр 5, Хуульчдын холбооны шагналаар 1, Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын Жуух бичгээр 3 албан хаагчийг тус тус шагнасан. Төрийн дээд шагналаар 5 албан хаагчийг шагнуулахаар холбогдох баримтыг бүрдүүлэн МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 6.4.2 | Комиссын алба хаагчдын сургалтын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу чадавхыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах; | Мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдсэн байна.<br><br>ЗУХ | 1 | 100% | Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц болон богино хугацааны сургалт- Эхний хагас жилд төсвийн зардлаар эрхэлсэн түшмэлийн сургалтад 2, ахлах түшмэлд 1, төрийн албанд анх орох иргэний чиглүүлэх сургалтад 1, давтан сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдаж төгссөн. 4-р улиралд Тэргүүн түшмэлийн сургалтад 2, эрхэлсэн түшмэлийн сургалтад 4, ахлах түшмэлийн сургалтад 5 албан хаагч нийт 11 албан хаагчийг хамруулж, байгууллагаас 17,820,000 төгрөг зарцуулсан. 2. Ажлын байрны сургалтууд- Архив, албан хэрэг хөтлөлт, компьютерын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, жагсаал цуглааны үед хууль сахиулах арга хэмжээний тухай зэрэг ажлын байрны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Давхардсан тоогоор нийт 175 албан хаагч хамрагдсан байна. 3.Шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтууд -Хүний эрхийн байгууллагын үндсэн чиг үүрэг, хэлтсүүдийн чиг үүрэг, төрийн албан хаагч, хүний нөөц, байгууллагын дотоод үйл ажиллагаа, албан хэрэгцээнд ашиглах системийн зааварчилгаа өгөх сургалтуудыг 3 удаа зохион байгуулж, шинээр томилогдсон 32 албан хаагч хамрагдсан. 4. Бусад байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн сургалтууд- УИХТГ, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Цахим хөгжлийн яам болон ОУХБ, Европын холбоо болон Залуучуудын Хөдөлмөрийн сүлжээ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад давхардсан тоогоор нийт 59 албан хаагч хамрагдсан. 5. Хувь хүний хөгжлийг дээшлүүлэх сургалтууд-хэвшмэл ойлголт ба шийдвэр гаргалт, зан үйлийн ухаан-төрийн албан хаагчийн хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, хувь хүний хөгжил, харилцааны ур чадвар, рационал сэтгэлгээ, ажлын байрны стресс, хэцүү харилцагчтай хэрхэн харилцах, дипломат ёс зэрэг сургалтуудыг зохион байгуулж | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | давхардсан тоогоор нийт 229 албан хаагч хамрагдсан. Сургалтуудад байгууллагын төсвөөс нийт 19,620,000 төгрөг зарцуулсан. | |
| 6.4.3 | Байгууллагын дэргэдэх зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах; | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар<br>Тамгын газар | 0 | 100% | Байгууллагын дэргэдэх Соёл, спорт, олон нийтийн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, дэд төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. | Үнэлгээ-100% |
| 6.4.4 | Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах, ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, тайлагнах; | Санхүүгийн төлөвлөлт, тайлагналтын чанар, тоо<br>ЗУХ | 1 | 12 | Комисс нь 2022 онд 2,597.9 тэрбум төгрөгийн урсгал, 142.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын, нийт 2,739.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 81,8 хувьтай байна. Жилийн эцсийн байдлаар 95 орчим хувийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байхаар тооцож байна. | Үнэлгээ-100% |
| 6.4.5 | Санхүүгийн үйл ажиллагааг хөтлөн зохион байгуулах, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах; | Санхүүгийн үйл ажиллагаа, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажилласан байна<br>ЗУХ | 1 | 1 | Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 27 нэр төрлийн 10.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022.02.21, 2022.07.01-ны өдөр тус тус хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хариуцсан мэргэжилтнээс "Нэгэнт актласан хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох зохицуулалт байхгүй, харин өмч хамгаалан байнгын зөвлөлийн шийдвэрээр бараа материалд бүртгэн ажиллана уу" гэсний дагуу ХЭҮК-ын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр бараа материал ангилалд бүртгэн авсан.<br>2022 онд хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааг үнэлгээний хороо байгуулан зохион байгуулж 103.2 сая төгрөгийн 16 нэр төрлийн 75 ширхэг тоног төхөөрөмжийг Би Си Ти ХХК-иас, 38,4 сая төгрөгийн 11 нэр төрлийн 74 ширхэг тавилга, эд хогшлийг Хашхан ХХК-иас хүлээн авч бүртгэлд тусгасан. Үндсэн хөрөнгийн улсын үзлэг тооллогонд хамрагдаж ТӨБЗГ-т холбогдох материалыг хүргүүлэн ажилласан байна. | Үнэлгээ-100% |
| Зорилт 6.5 | | Хүний эрхийн комиссын үйл ажиллагааг цахим шилжилтийн бодлогод нийцүүлэн хөгжүүлэх | | | | |
| 6.5.1 | Хүний эрх аппликэйшныг шинэчлэн хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хүлээн авах зэрэг ажлыг хариуцах: Байгууллагын цахим хуудсыг | Хөгжүүлэлтийн ажил хийгдсэн байна.<br>ХЭССХ | 20% | 100% | "Хүний эрх" аппликэйшн хийх ажлын даалгаврыг боловсруулж, холбогдох нэгжүүдээс болон ЦХХХЯ-ны Бодлого зохицуулалтын газраас санал авсан. Санал авсан хувилбар болон шаардагдах төсвийн талаар Комиссын хуралд танилцуулсан бөгөөд хурлаас "Хүний эрх" апп-ыг 2023 онд хөгжүүлэхээр хойшлуулсан.<br>Байгууллагын цахим сайт шинэчлэлт хийх гэрээ байгуулж сайтын загвар дизайн хийгдэн кодчиллын шатандаа явж байна. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлүүлэх ажлын даалгаврыг гаргаж, гүйцэтгүүлэх | | | | | |
| 6.5.2 | Байгууллагын мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах; | Мэдээллийн технологийн засвар үйлчилгээг тогтмол хийх, хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.<br><br>ЗУХ | 0 | 100% | Комиссын мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс интернэтийн хэвийн ажиллагаа, Комиссын гишүүд, албан хаагчдад мэдээлэл технологийн туслалцаа дэмжлэгийг тухай бүр үзүүлсэн. Мөн дараах ажлуудыг шинээр хийж гүйцэтгэсэн.<br>- Орон нутгийн нийт албан хаагчийн компьютерт 128SSD хард, 8GB RAM нэмж суурьлуулж, үйлдлийн системийг шинэчлэж, хэрэглээний програм хангамж суулгасан.<br>- Нийт албан хаагчдын компьютерт Болор дуран алдаа шалгагч програм суулгасан.<br>- Нийт албан хаагчдын компьютерт Microsoft office 2019, Windows 10, 11 үйлдлийн системийн албан ёсны лицензийг суулгасан.<br>- nhrcm.gov.mn цахим хуудасны зарим засвар, үйлчилгээ болон мэдээ тайлан оруулах, илтгэлийн хувилбар оруулах ажлуудыг хийсэн.<br>- live төхөөрөмж болон Дүрс бичлэгийн камерын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. | Үнэлгээ-100% |
| ХОЁР: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ | | | | | | |
| 2.1 | Комиссын хуралдаан, гишүүдийн хурал, уулзалт, Тамгын газрын хурлын үйл ажиллагааны бэлтгэл зохион байгуулалтыг хангах, тэмдэглэл хөтлөх, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнах | Шийдвэрийг нь баталгаажуулж, тэмдэглэл бичсэн хурлын тоо<br>ЗУХ | 12 | 12 | Комиссын ээлжит хурлыг тайлант хугацаанд 8 удаа, ээлжит бус хурлыг 3 удаа зохион байгуулж нийт 37 асуудлыг хэлэлцсэн байна. Хурлаар хэлэлцсэн асуудлын тэмдэглэлийг тухай бүр боловсруулж, холбогдох албан хаагч нарт танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Тамгын газрын хурлыг 9 удаа зохион байгуулж, хурлаас гарсан үүрэг даалгавар, шийдвэрийг танилцуулж, хэрэгжүүлж ажилласан. | Үнэлгээ-100% |
| 2.2 | Байгууллагын стратеги төлөвлөгөө (2021-2026 он)-ний хэрэгжилтийг хангаж, тайлагнах | Хууль, журамд нийцүүлэн боловсруулж батлуулсан стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттайгаар хангасан байх<br><br>Тамгын газар | 0 | Тийм | Хүний эрхийн Үндэсний Комиссын 2022-2025 онд баримтлах стратеги төлөвлөгөөний төслийг Комиссын гишүүд, ахмадууд, албан хаагчдаар хэлэлцүүлж, санал авч эцэслэсэн бөгөөд Комиссын даргад батлуулахаар өгсөн байна. | Үнэлгээ-100% |
| 2.3 | Байгууллага, нэгжийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээний | 0 | 5 | Байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 дүгээр сард хуулийн хугацаанд баталж, хэрэгжилтийг сар бүр тайлагнаж ажилласан бөгөөд Комиссын бүтцийг шинэчлэн баталсантай | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулж, тайлагнах | тайланг нэгж, ажилтнуудаас авч хугацаанд нь цахим хуудаст байршуулсан байна.<br><br>Тамгын газар | | | холбоотойгоор байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 дүгээр сард дахин боловсруулан баталж, хэрэгжилтийг сар бүрийн Комиссын хуралдаанд тайлагнаж ажилласан. | |
| 2.4 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж тайланг хугацаанд нь гаргасан байна<br><br>Тамгын газар | 0 | Тийм | Тамгын газрын албан хаагчид төрийн албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 болон 9 сард батлуулж, хэрэгжилтийг сар бүр тайлагнаж ажилласан. Тамгын газрын даргын 2022.06.15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар эхний хагас жилийн, 2022.12.02-ны А/96 дугаар тушаалаар бүтэн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх Үнэлгээний баг байгуулагдан албан хаагчдыг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэсэн. | Үнэлгээ-100% |
| 2.5 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа заавар, журмын дагуу хэвийн явуулах | Албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг заавар, журмыг дагуу хэвийн явуулж, тайлагнаж, архивласан байна.<br><br>Тамгын газар | 78,5 % | 100% | Албан хэрэг хөтлөлтийн хүрээнд: Комисст 2022 онд ирсэн бичиг 1014, өргөдөл, гомдол 891-г бүртгэн ажилласан. Явуулсан албан бичиг нийт 1278, Комиссын зөвлөмж 3, Гишүүний зөвлөмж 43, Гишүүний шаардлага 25-ыг хэвлэмэл хуудаст буулган албажуулж бүртгэсэн. Албан хэрэг хөтлөлтийн тайлан мэдээг (нийт ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдол тэдгээрийн шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, мэдээ) 7 хоног, сар тутам гаргаж хэлтсийн даргад танилцуулж ажилласан.<br>Шуудангаар явуулах бичгийн бүртгэл, “ГАРТ НЬ” тэмдэглэлтэй ирсэн бичиг, өргөдөл, гомдлын бүртгэл, албан хаагчдад албан хэрэг хөтлөлтийн бүртгэл, программаас мэдээлэл өгсөн бүртгэлийн дэвтрийг тус тус хөтлөн, албанд ашиглан ажиллаж байна.<br>Архивын ажлын хүрээнд: 2021 онд үүсч хөтлөгдсөн нийт 285 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивт хүлээн авч бүртгэлжүүлэн ажилласан.<br>2001-2003 оны 4119 хуудас баримтыг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан болон илүү хувь баримтыг ялган устгах баримтын жагсаалтад бүртгэсэн.<br>2004-2008 оны 4 хайрцаг өргөдөл гомдын баримтыг нягтлан шалгасан.<br>Байгууллагын 2001-2021 оны захирамжлалын 53 хадгаламжийн нэгжийн 3435 хуудас баримтыг цахимжуулсан.<br>Архивын ерөнхий газарт  Төрийн архивын систем ашиглах эрх нээлгэхээр албан бичиг явуулсан. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүний эрхийн Үндэсний Комиссын Байгууллагын архивын журмын төслийг боловсруулан АЕГ-н Мэргэжил, арга зүйн удирдлагын газарт хянуулахаар явуулсан.Цахим номын санд нийт 17 номыг оруулсан. | |
| 2.6 | “Төрийн албан хаагчийн ёс зүй, авлига, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, хяналт тавьж, тайлагнах. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар<br><br>ЗУХ | 100% | 100% | 2021 оны Хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргаж байгаа албан хаагчдын цахим мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, арга зүйн заавар, зөвлөгөө өгч ажилласан. Нийт 36 мэдүүлэг гаргагч хуулийн хугацаанд мэдүүлгээ ирүүлж, баталгаажуулсан. 2021 оны тайланг ХАСХОМ-1, ХАСХОМ-2 маягтаар гаргаж АТГ-т албан бичгээр хүргэсэн.<br>Гэрээ байгуулах асуудлаар гаргасан ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай 67 мэдэгдэл тайлбарыг meduuleg.iaac.mn цахим системд бүртгэсэн.<br>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 39 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт албан бичгээр хүргүүлж, ирүүлсэн хариуг үндэслэн холбогдох албан тушаалд нь томилсон бөгөөд 24 иргэний томилогдсоноос хойш 30 хоног дотор гаргасан мэдүүлгийг хянаж баталгаажуулсан. Тамгын газрын даргын 2022.05.12-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл байгуулж, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллав. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлаар 10 сард 2 удаа хуралдаж, ёс зүйн зөрчил гаргаагүй гэж дүгнэсэн. | Үнэлгээ-100% |
| 2.7 | Комиссын гишүүдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх<br><br>Тамгын газар | 0 | Тийм | Энэхүү ажлын хүрээнд дарга, гишүүдийн туслахууд тэдний оролцсон уулзалт, хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж, техникийн туслалцаа үзүүлж ажилласан байна. Үүнд:<br>-Комиссын дарга Ж.Хунан 30 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг;<br>- Комиссын гишүүн Б.Энхболд, Х.Мөнхзул нар 71 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг;<br>-Комиссын гишүүн Д.Сүнжид 15 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг;<br>-Комиссын гишүүн С.Дондов 35 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг;<br>-Комиссын гишүүн Г.Нарантуяа 13 удаагийн уулзалт хэлэлцүүлэгт тус тус оролцсон байна.<br>Мөн тухай бүр гишүүд болон Тамгын газрын даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан.<br>ХЭССХ- ээс дарга, гишүүдэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 15 хичээлийн агуулга бэлдэж ппт хийсэн, шаардлагатай асуудлаар 20 удаагийн мэдээлэл бэлдсэн. | Үнэлгээ-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 2.8 | Байгууллагын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээг төлөвлөж, хэрэгжилтийг хангуулж, тайлагнах | Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.<br><br>ЗУХ | 0 | 100% | Дотоод хяналт шалгалтын ажлын 2022 оны төлөвлөгөө болон Комиссын үйл ажиллагаанд хамаарах бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, бусад баримт бичгийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх календарчилсан төлөвлөгөөг баталж төлөвлөгөөний дагуу Комиссын чиг үүрэгт хамаарал бүхий 31 хуулийн 233 зүйл заалт, УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл болон Комиссын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 25 дүрэм журам, хөтөлбөрийн жагсаалтыг хяналтад авсан. Байгууллагын шилэн данс, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж, цахим хуудасны үйл ажиллагаа, 2022 оны хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, өргөдөл гомдлын шийдвэрлэлт зэрэгт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж дүгнэлтийг хүргүүлж ажилласан. | Үнэлгээ-70% |
| 2.9 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Зохион байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь<br><br>ЗУХ | 0 | 100% | 1.Төрийн үйлчилгээг иргэн бүрд нээлттэй, тэгш, хүртээмжтэй хүргэх, мэдээллээр хангах, иргэдийн санал хүсэлтийг байнга хүлээн авч, шийдвэрлэх, үйл ажиллагаандаа тусгах, төр иргэн хоорондын харилцааг зохицуулах, хүний эрхийн чиглэлээр иргэдээс асуумж, санал хүсэлт, мэдээлэл дэлгэрэнгүй авах зорилгоор байгууллагын суурин утсыг “Callpro” үйлчилгээнд шилжүүлсэн.<br>2. Комиссын Тамгын газрын 2022 оны А/69 дүгээр тушаалаар “Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн байгуулж албан томилолтоор орон нутаг, гадаад улсад ажилласан 27 албан хаагчийг гэнэтийн ослын даатгалд хамруулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг өгч, бүртгэл үйлдсэн.<br>3. “Дэлхийн цусны донорын өдөр”-ийг угтан ЗГ-ын 11 дүгээр байрны нийт байгууллагын албан хаагчдыг оролцуулсан аяныг зохион байгуулсан. | Үнэлгээ-100% |
| 2.10 | Дотоод хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр санамж бичиг, гэрээ байгуулах, уулзалт зохион байгуулах, төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангуулах. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар<br><br>ЗУХ | 0 | 100% | Батлан хамгаалах яам болон Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизтэй хамтран ажиллах санамж бичгийг 2024 он хүртэл байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>УИХ-ын 2022.07.06-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 49 дүгээр тогтоолын 4 дэх заалтад туссан“Цэргийн албан дахь дүрмийн бус харьцааны эрх зүйн зөрчлийн нөхцөл байдлын талаар авах арга хэмжээ”-г хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штабтай байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | Үнэлгээ-90% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 2.11 | Төсөл хөтөлбөрийн мэдээллийн сан үүсгэж, хэрэгжилтийг холбогдох нэгжээс тухай бүр гаргуулах авч, улирал тутам нэгтгэж удирдлагыг мэдээллээр хангах. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар<br><br>ЗУХ | 0 | 100% | 2019-2022 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийг нэгтгэж, дүн шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэсэн. Төрийн албыг чадавхжуулах хүрээнд Комиссоос хэрэгжүүлж буй 6 төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг нэгтгэж Төрийн албаны зөвлөлд 2022.11.04-ний өдөр хүргүүлсэн. Мөн 2022 онд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн мэдээг эхний 9 сарын байдлаар нэгтгэж удирдлагад танилцуулсан. | Үнэлгээ-90% |
| | Нийт | | | | | 84.52 |

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС